



МАНДАХ ИХ СУРГУУЛЬ

**БАГШ НАРЫН ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ
ХУРЛЫН ЭМХЭТГЭЛ – 2022**

СЭДЭВ: “Дижитал эриний нийгэм, эдийн засаг, бизнес, технологи”

**УЛААНБААТАР ХОТ
2023 ОН**

Эмхэтгэсэн: С.Цэвээнжаргал /ЭШСХ-ны нарийн бичиг/

Хянасан: А.Наранцэцэг /Доктор, дэд профессор, Эрдэмтэн нарийн бичгийн дарга/

ӨМНӨХ ҮГ

Эрдэмтэн багш, судлаач оюутнуудын бүтээлийг олон нийтэд сурталчлан таниулах, залуу судлаачдын эрдэм судалгааны ажлын арга зүйд ахиц дэвшил гаргах, харилцан мэдээлэл, туршлага солилцох, шинжлэх ухаан, инновацийн төсөл, санааг хэрэгжүүлэхэд бусад судлаач, ажил хэрэгч хүмүүстэй хамтарч ажиллахад тус нэмэр болох зорилгоор Мандах Их Сургуулийн судлаач оюутнуудын эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг эмхэтгэн гаргадаг уламжлалтай.

Мандах Их Сургуулийн багш нарын эрдэм шинжилгээний хурал 2023 оны 01 сарын 16 - ны өдөр зохион байгуулагдлаа. Энэ удаагийн эрдэм шинжилгээний хуралд судалгааны баг бүрээс ирүүлсэн нийт 8 илтгэл хэлэлцүүлсэгдсэн бөгөөд үүнээс Б.Сайнжаргал багшийн илтгэл нь Докторын зэрэг хамгаалсан бүтээл учраас эмхэтгэлд нэгтгэгдээгүй. Хэлэлцүүлэгдсэн илтгэлийг хурлын хөтөлбөрийн дарааллаар эмхэтгэв.



Зочин илтгэл: О.Баттуяа "Судлаачийн ёс зүйн асуудал"

13:10-13:33 РМ

Илтгэгч: Н.Далайсайхан, М. Ганхөлөг

"Хичээлийн хөтөлбөрийн үнэлгээг SURE загвараар үнэлэх нь"

13:35-13:45 РМ

Илтгэгч: Х.Сувд-Эрдэнэ

"Хувь хүний менежментэд мэдээллийн систем ашиглах нь"

13:47-13:57 РМ

Илтгэгч: С.Ганцэцэг, Т.Оюун-Эрдэнэ

"Мэргэжлийн англи хэлний хичээлээр төлөвших оюутны хандлагад хийсэн судалгаа"

14:00-14:10 РМ

Илтгэгч: Д.Түвшинжаргал

"Уламжлалт аргаар аарц шахах төхөөрөмжийг загварчилсан үр дүн"

14:13-14:23 РМ

14:25-14:40 РМ: АСУУЛТ ХАРИУЛТ 1-Р ХЭСЭГ ХЭСЭГ

Илтгэгч: Б.Гэрэлмаа

"A Study on Antecedents Affecting E-Satisfaction in the Mongolian Postal Service Sector"

14:40-14:50 РМ

Илтгэгч: Ц.Цолмон

"Барилгын цахилгаан хангамжид сэргээгдэх болон төвийн эрчим хүчийг хослуулан ашиглах боломжийн судалгаа""

14:53-15:03 РМ

Илтгэгч: Б.Сайнжаргал

"Хэрэглэгчийн зах зээлийг сэтгэл зүйн үзүүлэлтээр сегментчлэх арга зүйн асуудал" (Арилжааны банкны жишээн дээр)

15:05-15:15 РМ

Илтгэгч: Г.Алтанзаяа

"Дижитал эдийн засаг дахь татварын аюулгүй байдал"

15:17-15:27 РМ

ХИЧЭЭЛИЙН ХӨТӨЛБӨРИЙН ҮНЭЛГЭЭГ SURE ЗАГВАРААР ҮНЭЛЭХ НЬ

М.Ганхөлөг^{1a}, Н.Далайсайхан^{2b}

^{1,2} Мандах Их Сургууль, Суурь шинжлэх ухааны тэнхим, Багш

^agankhulug@mandakh.edu.mn

^bndalaisaikhan@mandakh.edu.mn

ХУРААНГУЙ

Энэхүү судалгаагаар “Эконометрикс” хичээлийн хөтөлбөрийн судалгааг хичээлийн хөтөлбөр, хичээлээр эзэмших ур чадвар хэр зохицой байгаа эсэхийг 2 үндсэн бүлэг, 24 дэд асуулгын хүрээнд бүтцэд суурилсан SURE загвараар үнэлэх зорилго дэвшүүлэн үнэлсэн.

Тус хичээлийг судалж буй оюутнуудаас хичээлийн хөтөлбөрийн асуулга бөглүүлэн судалгаа авч өгөгдлийг боловсруулан, 3 төрлийн үнэлгээ гарган тодорхойлсон. Дэвшүүлсэн зорилтуудыг дүгнэн “Эконометрикс” хичээлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэгч багш нарын хувьд ч анхаарвал зохих санал, зөвлөмжийг боловсруулсан. Мөн бусад хичээлийн хөтөлбөрийн судалгааг SURE загвараар үнэлэх санал, зөвлөмжийг толилуулсан болно. Энэхүү судалгаа нь хичээлийн хөтөлбөрийн хэрэгжилт, сургалтын үйл ажиллагааг үнэлэх, цаашлаад сургалтын үйл ажиллагаанд дүн шинжилгээ хийх, хичээлийн багийн заах арга зүйг сайжруулахад ашиглах боломжтой юм.

Түлхүүр үг: Үнэлгээний SURE загвар, цуваа бүтэц, зэрэгцээ бүтэц, хичээлийн хөтөлбөрийн үнэлгээ, хичээлийн ур чадвар

УДИРТГАЛ

Мандах Их Сургуулийн хувьд байгууллагын үнэт зүйлээ чанартай сургалт, чадварлаг мэргэжилтэн, ёс зүй хариуцлага, оюунлаг хүнлэг, иэгдмэл байдал хэмээн томъёолсон байдаг. Тэгвэл чанартай сургалт, чанартай боловсролын үйлчилгээ үзүүлэхийн тулд сургалтын хөтөлбөрийг бүрдүүлж байгаа бие даасан хичээлүүдийн хөтөлбөрт тодорхой үнэлгээний аргачлалыг ашиглаж дүн шинжилгээ хийх нь зүйтэй гэж үзэж байна. Тиймээс бүтэц дээр суурилсан Sure загвараар “Эконометрикс” хичээлийн хөтөлбөрийн жишээн дээр үнэлгээ хийлээ.

Энэхүү судалгааны ажлын хувьд тухайн хичээлийг зааж буй багшийн зүгээс судалгааны асуултаа боловсруулан өгөгдлөө оюутнуудаас цуглуулан өөрийн үнэлгээ хийж хэвших, тодорхой нэг үнэлгээний загварыг ашиглах, улмаар цаашид хичээлээ сайжруулах, хөгжүүлэх, хөндлөнгийн үнэлгээнд бүтээлчээр хандах үндэс болох ач холбогдолтой юм.

Сургалтын үнэлгээний шинжлэх ухааны үндэслэлтэй, батлагдсан, хэрэглэгдэж буй “People–Process–Product Continuum Model” – Цахим сургалтын ЗР загвар, CIPP Model (Context, Input, Process, Product) – Үнэлгээний CIPP загвар, “Four Levels of Evaluating Learning” гэх мэт маш олон загваруудын уншиж мэдсэн бөгөөд эдгээр нь өөрийн онцлог давуу болон сүл

тaluудтай юм.¹ Ихэнх загваруудын хувьд тодорхой шалгуур буюу criteria дээр үндэслэгддэг, шугаман аргаар тооцоологдог байна.

Бидний хэрэглэсэн SURE загвар нь хичээлээ бүтээлчээр үнэлж, багшийн заах арга барил, хичээлд хэрэглэгдэж буй сургалтын материал, сургалтын орчин, сургалтын үнэлэх арга хэлбэрүүд, оюутны эзэмшиж буй мэдлэг чадвар хэр тохирч, зорилгоо биелүүлж чадаж байна уу гэдгийг үнэлэх шинжлэх ухааны үндэслэлтэй, математик аргачлалын нийцтэй байдлыг хангасан арга юм. Мөн үнэлгээг хийхдээ асуудал болон өгөгдөлөө шат дараалалтай боловсруулан цуваа болон зэрэгцээ бүтцэд оруулан нийлмэл цогц үйлдлээр үр дүнг тодорхойлж өгдөг арга юм.

Судалгааны зорилго: Хичээлийн хөтөлбөрийн судалгааг бүтэц дээр суурилсан SURE загвараар үнэлж, хөтөлбөрийн үнэлгээнд анхаарах асуудлыг илрүүлэх, хөтөлбөрийн судалгаа авах тодорхой санал зөвлөмж гаргах.

Зорилт:

1. Эконометрик хичээлийн хөтөлбөрийн ерөнхий үнэлгээг тодорхойлох
2. Хөтөлбөрийн үнэлгээний үндсэн 2 зорилго тус бүрийн үнэлгээг тодорхойлох
3. Хөтөлбөрийн үнэлгээний дэд 24 зорилго тус бүрийн үнэлгээг тодорхойлох
4. Судалгаанд оролцсон оюутан тус бүрийн үнэлгээг тодорхойлох
5. Хөтөлбөрийн үнэлгээний дүгнэлт гаргаж, тухайн хичээлийн хүрээнд анхаарах санал, зөвлөмж боловсруулах.
6. Хөтөлбөрийн судалгаа авах тодорхой санал зөвлөмж гаргах.

Судалгааны арга зүй

“Эконометрикс” хичээлийн хөтөлбөрийн судалгааг бүтэц дээр суурилсан SURE загвараар үнэлэхдээ хичээлийн хөтөлбөрийн үнэлгээний хэсэг, хичээлийг судалснаар эзэмших ур чадварууд гэсэн 2 бүлэгт авч үзсэн.

1. SURE загварын эхний үе шатанд үнэлгээний үндсэн зорилгуудыг тодорхойлох ба 2 үндсэн зорилгыг авч үзэж байна.
 - B1- Хичээлийн хөтөлбөр
 - B2- Хичээлийн ур чадварууд
2. Эхний үе шатанд тодорхойлсон үндсэн зорилгуудыг задлан дэд зорилгуудад хувааж эдгээр дэд зорилгуудыг тодорхойлсон.

B1-Хичээлийн хөтөлбөр

1. Сурч, мэдэх зүйл нь надад ойлгомжтой байсан
2. Явцын үнэлгээ / зөвлөмж/ нь дараагийн ажлуудыг бэлтгэж, гүйцэтгэх түлхэц болдог
3. Агуулга нь миний өмнө судалсан хичээлтэй холбоотой байсан
4. Сэдэв бүрийн агуулга нь хичээлийн ерөнхий зорилготой уялдаа холбоотой байсан
5. Бие даан гүйцэтгэж буй ажлууд нь хичээлийн хөтөлбөртэй уялдсан

¹ Цахим сургалтын үнэлгээний чиглэл ба загвар – Focus and models of evaluation of the e-learning

6. Үндсэн сурах бичиг хөтөлбөрийн агуулгатай нийцтэй байсан
7. Ачаалал тохиromжтой байсан
8. Оюутныг үнэлэх шалгуурыг хичээлийн эхэнд тодорхой дурдсан байсан
9. Дүгнэх үнэлгээний хуваарилалт нь энэ хичээлээр олгох мэдлэг ур чадвартай нийцдэг


B2 - Хичээлийн ур чадварууд

1. Багаар ажиллах
2. Задлан шинжлэх, шүүмжлэлтэй хандах
3. Мэдээлэл олох, үнэлэх, ашиглах
4. Асуудал шийдвэрлэх чадвараа хөгжүүлэх
5. Зөв үнэлгээ дүгнэлт хийх арга барил хандлагатай болох
6. Аливаа зүйлийг логик дэс дараатай сэтгэх
7. Няхуур нямбай эмх цэгтэй болох
8. Өгөгдлийг хэрхэн сонгох, ангилах болон үнэлэх
9. Хоёр хувьсагчийн харилцан хамаарлыг шугаман регресс ашиглан үнэлгээ хийх
10. Олон хувьсагчтай шугаман регрессийн үнэлгээ хийх
11. F болон t тархалтыг ашиглан төрөл бүрийн таамаглал шалгах
12. Хуурмаг хувьсагч агуулсан регрессийн шинжилгээг хийх
13. Үлдэгдэл хувьсагчийн автокорреляцийг шалгах, авторегрессийн хэрхэн үнэлэх
14. Эдийн засгийн хүчин зүйлсийг нэгийг нь нөгөөгөөр нь хэрхэн хамууруулж үнэлэх шугаман бус эконометрик загвар гаргах
15. Судалгааны ажил хийх анхан шатны суурь мэдлэгтэй болох

Дэд зорилгын логик бүтцийг зураг1-т харуулав.

Evaluation structure

3. Үнэлгээний зорилгуудыг бататгах. Үнэлгээний зорилго, дэд зорилгыг тодорхойлсны үндсэн дээр хичээлийн хөтөлбөрийн судалгааны асуулганд тулгуурлан боловсруулсан.
4. Асуулгыг боловсруулах. Хичээлийн хөтөлбөрийн судалгааны SURE загварын асуулгыг хичээлийн хөтөлбөрийн судалгааны асуулганд тулгуурлан дэд зорилгын бүтцийн дагуу



Зураг 1 Хөтөлбөрийн
үнэлгээний зэрэгцээ бүтэц

боловсруулан Google form ашиглан эконометрикс хичээлийг судлаж буй 129 оюутнаас 5 хоногийн хугацаанд судалгаа авч SURE загвараар боловсруулсан.

5. Өгөгдөл цуглуулах. Хичээлийн хөтөлбөрийн судалгааны үнэлгээний 24 асуултын дагуу өгөгдлийг цуглуулсан.
6. Өгөгдлийг боловсруулах. Бүтэц дээр суурилсан үнэлгээний загварын гол давуу талуудын нэг нь математик аппарат буюу хэмжээсийн онол дээр үндэслэн, логик бүтэцтэй уялдуулан тодорхойлсон өгөгдлийг тооцоолох аргачлал юм.

Үнэлгээний нэгдсэн дүнг

$$Q^*(C) = \frac{1}{n} \sum_{k=1}^n \prod_{i=1}^r \left(1 - \prod_{j=1}^{s_i} (1 - q_{ij}^{*(k)}) \right)$$

томъёогоор тооцож гаргана. Энэхүү математик томъёолол нь Sure загварын үндэс юм.

Эконометрикс хичээлийн хөтөлбөрийн SURE загварын үнэлгээ

Хичээлийн хөтөлбөрийн судалгааг 2 бүлэг бүхий 24 асуулганд тулгуурлан, дэд зорилгын бүтцийн дагуу боловсруулж, үнэлгээг 1-4 оноогоор өгч, Google form ашиглан эконометрикс хичээлийг судлаж буй 129 оюутнаас судалгааг авч, SURE загвараар боловсруулсан².


SURE model evaluation

Number of key goals: 2
 Numbers of sub goals: 9, 15
 Evaluation interval: [1,4]
 Number of data records: 129

Үнэлгээний хэмжээсүүд 1-4 гэсэн тоон үзүүлэлтээр дараах байдлаар илэрхийлсэн. Үүнд:

- 4 – Санал нийлж байна
- 3 – Зарим талаар санал нийлж байна
- 2 – Санал нийлэхгүй байна
- 1 – Үнэлгээ өгөх боломжгүй

Sure загвар нь үр дүнг тооцоолоод үнэлгээний эрэмбийг оноо болон өнгөөр ялгаж харуулдаг бөгөөд өнгө тус бүр нь дараах үнэлгээг илэрхийлнэ.



Зураг 2 Хөтөлбөрийн үнэлгээний SURE загварын үнэлгээ


² <http://www.uranchimeg.com/sure/eva.php>

СУДЛАГААНЫ ҮР ДҮН

Хичээлийн хөтөлбөрийн үнэлгээний үндсэн 2 зорилго болон дэд 24 зорилтыг SURE загварын дагуу үнэлэхэд дараах үр дүн гарсан.

Үндсэн зорилгууд нь цуваа бүтцээр илэрхийлэгдэх ба дараах байдлаар үнэлэгдсэн.

B1- Хичээлийн хөтөлбөр $Q_e^*(B_1) = 0.947$



B2- Хичээлийн ур чадварууд $Q_e^*(B_2) = 0.923$

$1 - \alpha$	$q_{e,0}^*$	$Q_e^*(C)$	$q_{e,1}^*$	σ_e^*
0.90	0.9122	0.9328	0.9534	0.142
0.95	0.9083		0.9573	
0.99	0.9006		0.965	

Түүврийн хэмжээ 129, итгэх түвшинг 0.9, 0.95, 0.99 гэсэн 3 түвшинд сонгож, итгэх интервалыг тогтоож үзэхэд стандарт хазайлт 0.142 нь хэлбэлзэл дунд зэрэг байгааг харуулж байна.

Зураг 3 *Өгөгдсөн магадлал бүхий стандарт хазайлт*

Дэд зорилгуудыг зэрэгцээ бүтцээр үнэлсэн нь:

А. Хичээлийн хөтөлбөр үнэлэх 9 асуулгын хувьд дараах үнэлгээнүүд гарсан.

$Q^*(A11)$	$Q^*(A12)$	$Q^*(A13)$	$Q^*(A14)$	$Q^*(A15)$	$Q^*(A16)$	$Q^*(A17)$	$Q^*(A18)$	$Q^*(A19)$
0.7959	0.8295	0.8372	0.8837	0.9018	0.8062	0.8243	0.8630	0.8372

Оюутнуудын өгсөн үнэлгээнээс харахад хичээлийн хөтөлбөрийн явцын үнэлгээ, агуулга, бие даан гүйцэтгэж буй ажлууд, сурх бичиг хөтөлбөрийн агуулгатай нийцтэй байдал зэрэг оюутанд нийцтэй байсан гэдгийг илэрхийлж байна.

Б. Хичээлийн ур чадваруудыг үнэлэх 15 асуулгын хувьд дараах үнэлгээнүүд гарсан.

$Q^*(A21)$	$Q^*(A22)$	$Q^*(A23)$	$Q^*(A24)$	$Q^*(A25)$	$Q^*(A26)$	$Q^*(A27)$
0.7545	0.8140	0.8630	0.8165	0.8295	0.8269	0.8114

$Q^*(A28)$	$Q^*(A29)$	$Q^*(A210)$	$Q^*(A211)$	$Q^*(A212)$	$Q^*(A213)$	$Q^*(A214)$	$Q^*(A215)$
0.8269	0.8450	0.8398	0.8140	0.7907	0.8062	0.8062	0.8424

Ур чадваруудын хувьд бүтцийн үнэлгээ дийлэнх нь 0.8-аас дээш байгаа боловч, 0.8-аас бага үнэлэгдсэн багаар ажиллах ур чадвар дутмаг байгааг анхаарах шаардлагатай гэж үзсэн.

Evaluation table (empirical evaluation scores)

<i>k</i>	<i>B</i> ₁										<i>B</i> ₂															<i>Q</i> _{e,k} (C)
	<i>A</i> ₁₁	<i>A</i> ₁₂	<i>A</i> ₁₃	<i>A</i> ₁₄	<i>A</i> ₁₅	<i>A</i> ₁₆	<i>A</i> ₁₇	<i>A</i> ₁₈	<i>A</i> ₁₉	<i>A</i> ₂₁	<i>A</i> ₂₂	<i>A</i> ₂₃	<i>A</i> ₂₄	<i>A</i> ₂₅	<i>A</i> ₂₆	<i>A</i> ₂₇	<i>A</i> ₂₈	<i>A</i> ₂₉	<i>A</i> ₂₁₀	<i>A</i> ₂₁₁	<i>A</i> ₂₁₂	<i>A</i> ₂₁₃	<i>A</i> ₂₁₄	<i>A</i> ₂₁₅		
1	1	1	1	1	1	1	1	1	0.33	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1
2	1	1	1	1	1	1	0.67	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1
3	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1
4	0.67	1	1	0.67	1	1	1	1	0.67	0.67	1	1	1	1	0.67	0.67	0.33	0.67	1	1	1	0.67	0.67	0.67	1	1
5	0.33	0.33	0.67	0.67	0.67	0.67	0.33	0.67	0.67	0.33	0.33	0.33	0.33	0.33	0.33	0.33	0.33	0.33	0.33	0.33	0.33	0.33	0.33	0.33	0.44	
6	0.67	0.67	0.33	0.67	0.67	0.67	0.33	1	0.67	0.33	0.67	0.67	0.67	0.67	0.67	0.67	0.67	0.67	0.67	0.67	0.67	0.67	0.67	0.67	0.73	
7	0.67	0.67	1	0.67	1	0.67	1	0.67	0.67	0.67	1	1	1	1	1	0.67	0.67	0.67	0.67	1	1	0.67	0.67	1	1	1
8	0.67	0.67	0.67	0.67	0.67	0.67	0.67	0.67	0.67	0.67	0.67	0.67	0.67	0.67	0.67	0.67	0.67	0.67	0.67	0.67	0.67	0.67	0.67	0.67	0.67	
9	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1
10	1	1	1	1	1	1	0.67	1	1	0.67	0.67	1	1	1	1	0.67	1	1	1	1	1	1	1	1	1	1
11	1	1	0.67	1	1	0.67	1	1	0.67	0.67	0.67	0.67	0.67	0.67	0.67	0.67	1	1	1	1	0.67	0.67	0.67	1	1	
12	0.67	0.67	0.33	0.67	0.67	0.67	0.67	0.67	0.67	1	0.67	1	0.67	0.67	0.67	0.67	0.67	0.67	0.67	0.67	0.67	0.67	0.67	0.67	0.8	
13	1	0.67	0.67	1	0.67	0.67	1	1	0.67	0.67	1	1	1	1	0.67	1	0.67	0.67	1	0.67	0.67	0.67	0.67	1	0.67	1
14	1	1	0.67	0.67	0.67	1	0	0.67	0.67	1	1	1	1	1	0.67	0.67	0.67	1	1	1	0.67	0.67	0.67	0.67	1	1
15	0.67	1	1	1	0.67	0.67	0.67	1	0.67	0.67	1	0.67	0.67	0.67	0.67	0.67	1	0.67	0.67	1	0.67	0.67	1	0.67	1	1
16	0.67	0.67	0.67	0.67	0.67	0.67	0.67	0.67	0.67	0.67	0.67	0.67	0.67	0.67	0.67	0.67	0.67	0.67	0.67	0.67	0.67	0.67	0.67	0.67	0.67	
17	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1
18	0.67	1	0.67	0.67	1	0.67	0.67	0.67	1	1	0.67	0.67	1	0.67	0.67	0.67	0.67	0.67	1	1	0.67	0.67	0.67	0.67	0.67	1
19	0.67	0.67	0.67	1	1	1	0.67	0.67	0.67	1	1	1	0.67	1	1	1	1	1	1	0.67	0.67	0.67	1	1	1	1
20	0.67	0.67	1	1	1	0.67	0.67	0.67	0.33	0.67	1	1	0.67	1	0.67	1	1	0.67	0.67	0.67	0.67	0.67	0.67	0.67	1	1
21	1	1	1	1	1	1	1	1	1	0.67	0.67	0.67	0.67	0.67	0.67	0.67	0.67	0.67	0.67	0.67	0.67	0.67	0.67	0.67	0.82	
22	0.67	0.67	1	1	0.67	0.67	1	1	0.67	0.67	0.67	0.67	0.67	0.67	0.67	0.67	0.67	0.67	1	1	0.67	0.67	0.67	0.67	0.67	1
23	0.67	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1
24	0.67	0.33	0.67	0.67	1	1	0.33	1	1	1	1	1	1	1	1	1	1	0.33	0.33	0.33	0.33	0.33	0.33	0.33	0.33	1
25	0.67	0.33	0.67	0.33	0.67	0.67	1	0.33	0.33	0.67	0.33	0.33	0.33	0.67	0.67	1	0.67	0.67	0.67	0.67	0.67	0.67	0.67	0.67	1	
26	0.67	0.67	0.67	0.67	0.67	0.67	0.67	0.33	0.33	0.67	0.33	0.67	0.67	0.33	0.67	0.33	0.67	0.67	0.33	0.67	0.67	0.67	0.67	0.67	0.59	
27	0.67	1	0.67	1	1	1	0.67	1	1	1	1	1	0.67	0.67	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1
28	0.67	0.67	0.67	1	1	1	1	0.67	0.67	0.67	0.67	1	1	1	1	1	0.67	1	0.67	1	0.33	0.67	0.67	0.67	1	1

Зураг 4 Оюутан тус бүрийн харцуултын оноо

Sure загвар нь үр дүнг тооцоолоод үнэлгээний эрэмбийг оноо болон өнгөөр ялгаж харуулдаг бөгөөд өнгө тус бүр нь дараах үнэлгээг илэрхийлнэ. Тухайлбал: 5 онооны үнэлгээ өгсөн бол 1 буюу ногоон өнгөөр, 1 гэсэн үнэлгээ нь 0 буюу улаан өнгөөр харагдана.

Хичээлийн хөтөлбөрийг үнэлжээд тухайн хичээлийн судлаж байгаа 129 оюутан оролцож үнэлсэн ба хичээлийн хөтөлбөрийн үнэлгээ 0.933 гарсан нь экономтрикс хичээлийн хөтөлбөр чанартай байгааг илэрхийлж байна.

$$Q^*e(C) = 0.9327$$

ДҮГНЭЛТ

1. Эконометрикс хичээлийн хөтөлбөрийн ерөнхий үнэлгээг Sure загвараар үнэлэхэд 0.9327 буюу 93.27% -иар үнэлэгдлээ. Энэ нь 4 онооны системийн хувьд 3.8 онооны хоорондох үнэлгээ буюу хичээлийн хөтөлбөр чанартай гэж үнэлэгдсэн байна.
2. Тодорхойлсон үндсэн 2 зорилгыг цуваа бүтцээр үнэлэхэд хичээлийн хөтөлбөр 0.947, хичээлийн ур чадварууд 0.923 гэсэн ойролцоо үнэлэгдсэн байна.
3. Нийт 24 дэд зорилгуудаас хамгийн бага үнэлгээ авсан нь багаар ажиллах, хуурмаг хувьсагч агуулсан регрессийн шинжилгээг хийх гэсэн дүгнэлтэд хүрлээ.

САНАЛ, ЗӨВЛӨМЖ

1. Хичээлийн хөтөлбөрийн судалгааны үндсэн болон дэд зорилгуудыг илүү оновчтой тодорхойлж гаргах
2. Судалгааны өгөгдлийг цуглуулахдаа аль болох бодитой нямбай хандах
3. Дэд зорилгуудын хамгийн бага үнэлгээ авсан үзүүлэлтүүдийг сайжруулах тал дээр анхаарч ажиллах (багаар ажиллах, хуурмаг хувьсагч агуулсан регрессийн шинжилгээг хийх семинарын хичээл дээр)
4. Багш нар хөтөлбөрийн судалгаагаа SURE загвараар <http://www.uranchimeg.com/sure/eva.php> үнэлэх боломжтой.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

1. Uranchimeg Tudevdagva: Structure Oriented Evaluation Model for E-Learning. Wissenschaftliche Schriftenreihe Eingebettete Selbstorganisierende Systeme, Universitätsverlag Chemnitz, Chemnitz, Germany, July 2014. 123 p.
2. Т.Уранчимэг, С.Базаррагчаа, Э.Сэлэнгэ, (2021), Цахим сургалт: эм зүйч мэргэжлийн онлайн сургалтыг SURE аргачлалаар үнэлсэн туршилт, судалгаа, Дээд Боловсрол сэтгүүл, Д.1 (5), xx.95-99.
3. Т.Уранчимэг, (2021), Цахим сургалтын үнэлгээний SURE загварын өгөгдөл боловсруулах онлайн тооцооллын программ, Дээд Боловсрол сэтгүүл, Д.1 (5), xx.77-82,
4. SURE загварын онлайн тооцоолуур, (2022), Онлайн эх сурвалж: <http://www.uranchimeg.com/sure/eva.php>
5. SURE загварын мэдээлэл <http://uranchimeg.com/Education>

ХУВЬ ХҮНИЙ МЕНЕЖМЕНТЭД МЭДЭЭЛЛИЙН СИСТЕМИЙГ АШИГЛАХ НЬ

Х.Сувд-Эрдэнэ^{1,a}

¹Мандах Их Сургууль, Мэдээлэл технологийн тэнхим, Багш

^asuvderdene@mandakh.edu.mn

ХУРААНГУЙ

Энэхүү судалгааны ажилдаа хувь хүний менежмент тэр дундаа бие хүний санхүүгийн менежмент, эрүүл мэндийн менежмент, мэдлэгийн менежмент, хувь хүний цаг ашиглалт, хувь хүний төлөвлөгөө гаргалт, төлөвлөгөөндөө хүрсэн байдал, цаг зохицуулалтыг боловсронгуй болгох арга зам, гадаад орны төлөвлөгөө гаргах менежментийн харьцуулалт, олон улсын жишигт анализ хийж ажиллаа.

Энэхүү судалгааны ажлаараа үндсэн 3 асуултад хариулахыг зорилоо:

Үүнд:

1. Хувь хүний хөгжил гээж юу вэ?
2. Хувь хүний менежмент манлайлалд хэрхэн нөлөөлдөг вэ?
3. Менежментийн цахим хэрэгсэл, түүний ач холбогдолын үнэ цэнэ?

Түлхүүр үг: Хувь хүн, хувь хүний менежмент, удирдлагын мэдээллийн систем, хувь хүний менежментийн цахим хэрэгсэл

Abstract

This research project focuses on personal management, including personal financial management, health management, knowledge management, personal time management, personal planning, achievement of plans, ways to improve time management, and comparison of foreign planning management performed international standard analysis.

This research aims to answer 3 main questions:

It includes:

1. *What is personal development?*
2. *How does personality management affect leadership?*
3. *The value of electronic management tools and their importance?*

Keywords: Personal, personal management, management information system, personal management electronic tools

ОРШИЛ

Алсын хараа 2050-д тусгасан “Хүний хөгжил” салбарын хүрээнд судалгаа, нотолгоонд суурилсан бодлого, хөгжлийн төлөвлөлт, хяналт шинжилгээ, үнэлгээ хийх удирдлагын тогтолцоог бэхжүүлж, олон талт түншлэлийг бий болгох чиглэлээр хувь хүний менежментийг зөв зохион байгуулах, тэр дундаа Монгол Улсын ирээдүй болсон оюутан залуус цаашид улам илүү хөгжих, цагаа зөв төлөвлөх, цаг баримтлал, ажлын бүтээмжээ дээшлүүлэх, эрүүл мэнд гоо сайхандаа анхаарах, санхүүгээ зөв зохистой хэрэглэх, мэдлэгээ улам бүр баяжуулж хойшдоо энэхүү судалгааны ажлаар бүтээгдсэн программ хангамж болон мэдээллийн системийг амьдралдаа хэрэгжүүлж хэвшүүлэхэд чиглэн энэхүү сэдвийг сонголоо.

Судалгааны ажлын зорилго: Цаг төлөвлөлт зохион байгуулалт, эрүүл мэнд, санхүү гэх мэт хувь хүний менежментийн асуудлаарх сайн жишиг туршлагыг судалсны үндсэн дээр өөрийн улсын онцлогт тохирсон, өнөө үед хамгийн тохиромжтой мэдээллийн системийн боломжийг эрэлхийлж санал боловсруулах нь энэхүү судалгааны ажлын зорилго болно.

Дээрх зорилгыг биелүүлэхийн тулд дараах **зорилтуудыг дэвшүүлэн** судаллаа.

1. Менежментийн талаарх ойлголтыг судлах
2. Олон улсын менежмент, манлайллын талаарх ойлголтыг судлах
3. Монгол улсад залуучуудад тулгамдаж буй асуудлыг судлах, шийдвэрлэх арга замыг судлах
4. Гадаадын зарим улс орнуудын сайн жишиг, менежментийг судлах

Судалгааны хүрээ: Судалгааны хүрээг тодорхойлохдоо менежмент болон мэдээллийн системийн талаарх ойлголт, хоорондын уялдаа холбоо, хэрэгжилт, тулгамдаж буй асуудал болон гадаад орны төлөвлөлтийн талаар авч үзнэ.

Судалгааны арга: Энэхүү судалгааны ажилд ажиглалт хийх, харьцуулах менежментийн асуудлыг харьцуулан судалсан.

Судалгааны ач холбогдол: Судалгааны ач холбогдол нь хувь хүмүүст менежментийн тулгамдаж буй асуудал түүнийгээ хэрхэн шийдвэрлэх арга замыг тодорхойлсны үндсэн дээр цаг төлөвлөлт болон аз жаргалын менежментийн тогтолцоог боловсронгуй болгоход оршино.

Менежментийн үндэс

“Менежмент гэж юу вэ?” гэсэн асуултыг тавьж, менежментийн сурх бичгүүдээс мэдээлэл хайвал “Менежмент гэдэг нь бол байгууллагын зорилгод хүрэхийн тулд нөөцүүдийг үр ашигтай, үр дүнтэй арга замаар төлөвлөж шийдвэр гаргах, зохион байгуулах, манлайлах, хянах үйл ажиллагаануудын нэгдэл мөн³ юм.

Гэвч чухамдаа менежмент гэж юу юм бэ? Тэр энэхүү ерөнхий тодорхойлолтоор тодорхойлогдчих энгийн ойлголт уу, эсвэл тун өргөн хүрээг хамрах, адarmaатай ухагдахуун уу? Үүний хариултыг менежментийн сүүт эрдэмтэд, шилдэг менежерүүдийн хэлсэн үгсээс олж болох юм. Доорх эшлэлүүд тус бүрдээ бол өрөөсгөл, дутуу санааг илэрхийлж байгаа боловч

³ Б.Мөнхжаргал, Б.Амаржаргал. Менежмент. УБ., 2013 он. 15 дахь тал.

тэдгээрийг цогцоор нь уялдуулан харвал менежментийн ухааныг илүү нарийн ойлгоход тань тус болохоор олон өнцөг, бодууштай санаа, бодит үнэнийг өгүүлсэн байгаа. Мөн менежмент хэмээх ухагдахууны үүсэл, хөгжил, өөрчлөлт ч харагдана.⁴

“Менежмент гэдэг нь та яг юу хийхийг хүсэж байгаагаа олж мэдээд хамгийн шилдэг хүнээр хамгийн хямдаар хийлгүүлэх урлаг юм” хэмээн Ф.В.Тейлор хэлсэн байдаг. Түүнчлэн “Менежмент гэдэг нь хүмүүсээр ажил хийлгүүлэх урлаг юм” Мэри Паркер Фоллет, “Менежмент гэдэг нь албан ёсны бүлгийн ажилчдаар болон тэдэнтэй хамтарч ажил хийх урлаг” Харольд Коонз, “Менежмент нь таамаглах, төлөвлөх, зохион байгуулах, чиглүүлэх болон хянах үйл ажиллагаануудын нийлбэр цогц” Хэнри Фаеол, “Менежмент нь төлөвлөх, зохион байгуулах, урам зориг хайрлах болон хянах үйл ажиллагааны цогц бөгөөд өмнөө тавьсан зорилгыг биелүүлэхийн тулд урлаг болон ашигладаг” Жорж Р Терри, “Менежмент нь бизнес, менежерүүд болон ажилчдыг удирддаг олон үүрэг, үйлдэл бүхий арга ажиллагаа” гэж Петр Дракер зэрэг дээрх олон эрдэмтэд менежментийн талаарх өөр өөрсдийн байр суурийг илэрхийлж хэлсэн байдаг.

Менежмент гэдэг бол “Хүмүүсийн туламжтайгаар ажлыг биелүүлэхийг хэлнэ.” гэж тодорхойлсон судлаач Мери Паркер Роллетт, мөн ажлын үр дүн, бүтээмжийг дээшлүүлэхэд хүний асуудалд анхаарлаа хандуулах хэрэгтэй гэдгийг нээсэн судлаач Элтон Мэйо нарыг хүмүүс хоорондын харилцааны менежментийн онолыг үндэслэгчид гэж нэрэлдэг. Тэд удирдлага амжилтад хүрэх нөөцийг ажилчдын сэтгэл санаанд байдгийг анхааруулж, ажиллагсдын бүтээмж сэтгэл ханамжийг дээшлүүлэхэд хүмүүс хоорондын харилцааг жолоодох, ажиллагсад өөрийн чадавхaa бүрэн дайчилж гаргахуйц зан үйлийг төлөвшүүлэх асуудал чухал болохыг анхлан дэвшиүүлсэн байна.⁵



Төлөвлөлт ба Шийдвэр гаргалт: Үйл ажиллагааны нөөцүүдийг тодорхойлох Хамгийн энгийнээр хэлбэл төлөвлөлт гэдэг нь байгууллагын зорилгод хэрхэн хамгийн сайн арга замаар хүрэхийг тодорхойлно гэсэн үг. Харин шийдвэр гаргалт нь төлөвлөх үйл явцын нэг хэсэг бөгөөд түүнтэй холбоотой гарч ирэх хувилбаруудаас хамгийн боломжтойг нь сонгох явдал юм.

⁴ н.Энхбүргэд. Менежмент гэж юу вэ?. нийтлэлээс авав.

⁵ Ц.Цэрэндорж, С.Цэрэндамба. Бидний менежмент. УБ.,2010 он. 19 дэх тал.

⁶ Б.Мөнхжаргал, Б.Амаржаргал. Менежмент. УБ., 2013 он. 17 дахь тал.

Төлөвлөлт, шийдвэр гаргалт нь ирээдүйн үйл ажиллагаа үр дүнтэй болоход чухал ач холбогдолтой чиг үүрэг мөн. Жишээ нь: Женерал Электрикийн өрөнхий захирал Жак Уелч компанийнхаа бизнесийн нөөцүүдийг тухайн салбартаа тэргүүлэх, шилдэг байх зорилго тавьж байсан нь удирдлагуудын хувьд ойлгомжтой чиглэл болсон. Иймээс зорилго төлөвлөгөө гэдэг нь менежерүүдэд өөрсдийн цаг хугацаа, нөөцүүдийг хэрхэн хуваарилахыг мэдэхэд тусалдаг.

Зохион байгуулалт буюу нөөцүүд ба үйл ажиллагааны зохицуулалт: Менежерүүд ажлын төлөвлөгөөгөө боловсруулсны дараа түүний дагуу хүний болон бусад нөөцийг хуваарилан зохион байгуулах хэрэгтэй болно. Энгийн жишээ авч үзье. Танд төлөвлөгөөгөө хэрэгжүүлэхэд 3 ажилтан, 900000₮ байна гэж үзье. Ажилтан бүрд 300000₮ төсөв өгөөд хийсэн ажлаа тайлاغнах нэг хандлага байж болно. Эсвэл 2 ажилтан тус бүрд 450000₮ өгөөд үлдсэн нэг хүнийг тэдэнд туслах үүрэгтэйгээр оролцуулах бас нэг хандлага байж болох юм. Зарим амжилттай ажиллаж компаниуд үйл ажиллагаагаа салбарынх нь чиглэлээр харьцангуй бие даасан байдалтайгаар ажиллуулж хүнд суртлын дэг журам, горимыг өөрчилж чаддаг байна. Үйл ажиллагаа болон нөөцүүдийг бүлэглэн хэрэгжүүлэх арга замыг тодорхойлохыг зохион байгуулах үйл явц гэнэ.

Манлайлал буюу ажиллагсдыг удирдах ба идэвхжүүлэх: Зохион байгуулах үйл явц хийгдсэн гэж үзээд удирдлага ажиллагсадтайгаа гэрээ хийж ажлын байранд нь томилсноор бүх зүйл хүмүүсийн хувьд сэтгэл ханамжтай болсон гэвэл өрөөсгөл буруу ойлголт юм. Харин менежерүүд удирдлагын нэлээд төвөгтэй чиг үүрэг болох манлайлалд анхаарлаа хандуулах хэрэгтэй. Манлайлал гэдэг нь байгууллагын болон түүний гишүүдийн ашиг сонирхол хамт ижил түвшинд байлгахад хэрэглэгддэг үйл явц юм. Мөн манлайлагч нь өөрийгөө зөв удирдахын тулд дагаж мөрдөх хамгийн эхний дүрэм бол та чухам юуны учир байгаагаа ухамсарлаж, зөвхөн зөв зүйлийг хийхийг ухамсарлах явдал⁷ гэж ойлгож болно.

Хяналт буюу үйл ажиллагааг үнэлж дүгнэх, шалгах: Менежментийн сүүлчийн шат бол хяналт мөн. Байгууллагын зорилгодоо хүрэхэд чиглэсэн үйл ажиллагааг удирдлагын зүгээс шалгах хэрэгтэй болдог. Тухайлбал Үндэсний Сансар Судлалын Төв Улаан Нүдэн гариг хүрэх станцын нислэгийг байнга хянаж зөв замд нь оруулах залруулах арга хэмжээг авах зайлшгүй шаардлагатай. Амжилттай удирдахын тулд үр ашигтай үр дүнтэй байх явдалд хяналтын үүрэг чухал юм.⁸

Менежмент ба менежерүүдийг тодорхойлох нь: Менежментийн талаар олон янзын тодорхойлолт өгч болно. Эрт дээр үед "хүмүүсээр яг юуг хийлгэхийг хүсэж байгаагаа мэдсэний үндсэн дээр хамгийн зардал багатай, шилдэг аргаар тухайн ажлыг гүйцэтгүүлэх" хэмээн тодорхойлж байжээ. Өнөө үед менежмент иж бүрэн үйл явц болсонтой холбоотойгоор түүнд тодорхойлолт өгөхийн өмнө байгууллагын талаар ойлголттой болсон байх шаардлагатай.

Байгууллага гэдэг нь зорилгодоо хүрэхийн тулд зохион байгуулагдсан хамтран ажиллаж буй хоёр буюу түүнээс дээш хүмүүсийн нэгдэл мөн. Системийн онолын үүднээс аливаа байгууллага хүний /менежерийн авьяас, ажиллах хүч/, санхүүгийн /урт богино хугацааны


⁷ Гуннар Андерссон, Лейф Фиссен. Өөрийгөө болоод хамтран зүтгэгч нөхдөө танин мэдэх нь. УБ.,2005 он. 71 дэх тал. Орч: Л.Золзаяа, Б.Даваахүү.

⁸ Мөн тэнд.18 дахь тал.

капитал/, биет /түүхий эд, барилга, тоног төхөөрөмж/, мэдээллийн /шаардлага хангахуйц мэдээ, өгөгдөл/ хэмээх дөрвөн төрлийн орц буюу нөөцийг гадаад орчноосоо авдаг.

Менежмент гэдэг нь байгууллагын зорилгод хүрэхийн тулд нөөцүүдийг үр ашигтай, үр дүнтэй арга замаар төлөвлөж шийдвэр гаргах, зохион байгуулах, манлайлах, хянах үйл ажиллагаануудын нэгдэл мөн.

Хүснэгт 1 Менежментийн хамрах хүрээ⁹



Маркетингийн менежер нь түншүүд болон хэрэглэгчдэд өөрийн бүтээгдэхүүнийг тайлбарлан танилцуулах, сурталчлах үүрэгтэй бөгөөд үндсэн ажил нь бүтээгдэхүүнийг хөгжүүлэх, идэвхжүүлэх, борлуулалт болон хуваарилалтын асуудлыг шийдэх, зөвлөгөө өгөхөд¹⁰ оршдог.

Санхүүгийн менежер нь байгууллагын санхүүгийн нөөцөд гол анхаарлаа хандуул, бүртгэл тооцоо, бэлэн мөнгөний удирдлага, хөрөнгө оруулалтын асуудлыг хариуцах ёстой.

Уйлдвэрлэлийн менежер нь бүтээгдэхүүн үйлчилгээг бий болгох системийг бүрдүүлэх, үйлдвэрлэлийн хяналт, ажлын байрны сонголт, чанар зэрэгт хариуцлага хүлээнэ

Хүний нөөцийн менежер нь хүмүүсийг сонгон ажилд авах, халах, ажиллагсдын нийгмийн асуудлыг шийдэх, хүний нөөцийн төлөвлөлт, сургалт хөгжил, нөхөн хангарт зэрэг ажил үүрэг гүйцэтгэнэ. Сүүлийн үед хүний нөөцийн удирдлагын үнэ цэнийг илүүд үзэх болсон.

Захиргааны менежер нь удирдлагын тусгай ямар нэг чиглэлтэй холбоогүй ерөнхий үүрэг гүйцэтгэдэг. Захиргааны удирдлагын хамгийн сайн жишээг эмнэлэг сувилын газруудаас харж болно. Тэд зарим үед менежментийн үндсэн бүх чиглэлийн ажлыг хэрэгжүүлдэг.

Менежерүүдийн бусад төрлүүд нь олон байгууллагууд удирдлагын албан тушаалуудыг өөрийн байгууллагын онцлогоос хамааран бий болгосон байдаг. Тухайлбал: судалгаа хөгжлийн зөвлөхүүд, мэргэжилтнүүд гэх мэт¹¹ албан тушаалууд байна.

⁹ Мөн тэнд. 21 дэх тал.

¹⁰ Маркетингийн менежер. www.mcs.mn/job/маркетингийн_менежер

¹¹ Б.Мөнхжаргал, Б.Амаржаргал. Менежмент. УБ., 2013 он. 27 дахь тал.

Менежментийн хамрах хүрээ: Менежмент, менежерүүдийн тухай хүмүүс бодохдоо тэднийг зөвхөн ашгийн төлөө байгууллагуудад л ажилладаг хэмээн төсөөлдөг. Гэвч спорт, шашны болон бусад байгууллагуудын хувьд мөн л адил авч үздэг. Үнэн хэрэгтээ зорилгodoо хүрэхийн тулд хүний, материалын, санхүүгийн, мэдээллийн нөөцийг ашиглан хамтран ажиллаж буй хоёр буюу түүнээс дээш бүлэг хүмүүсийн хувьд ямар ч тохиолдолд менежмент шаардлагатай болдог¹² гэж үзсэн байна.

Манлайлал гэж юу вэ?

Манлайлал гэдэг нь тодорхой зорилгод хүрэхийн тулд баг эсвэл хувь хүнийг чиглүүлэх, урам зоригоор удирдан чиглүүлэх үйл ажиллагаа юм. Удирдагчид амжилтад хүрэхийн тулд өөрт хэрэгтэй үйлдлүүдийг хийхийг бусдыг урамшуулдаг. Гайхалтай удирдагч байхын тулд үр дүнтэй байхын тулд шаардлагатай ур чадваруудыг сурч, хөгжүүлэх шаардлагатай. Аз болоход хэн ч эдгээр ур чадвараа цаг хугацаа, дадлага хийснээр хөгжүүлж чадна. Удирдагчид нь гүйцэтгэх захирал, дээд түвшний удирдлагуудаас эхлээд хянагч, төслийн удирдагч хүртэл бүх түвшинд компани бүрд байдаг. Та шинэ ажилчдыг сургах эсвэл хурал удирдахдаа манлайллын ур чадварыг анхан шатны түнш болгон ашиглаж болно. Удирдагч бүр баг, нөхцөл байдлаас шалтгаалан тодорхой манлайллын хэв маяг эсвэл хэд хэдэн холимог байж болно. Удирдлагын олон хэв маяг байдаг бөгөөд үүнд: Ажил гүйлгээ: Зорилгodoо хүрэхийн тулд урьдчилан тодорхойлсон урамшууллыг тогтоодог, Өөрчлөлт: Компанийн зорилгоо тодорхойлох, түүнд хүрэхэд анхаарлаа төвлөрүүлдэг, Автократ: Үр ашгийг харгалзан зорилгоо тодорхойлоход анхаардаг, Ардчилсан: Багийн гишүүдийн санаа бодлыг сонсож, тусгах зорилготой Та тодорхой хувь хүн, төсөл эсвэл компаниудад хамгийн тохиромжтой манлайллын хэв маягийг сонгож болно¹³ гэж үздэг.

Хүчтэй манлайлах ур чадварын ашиг тус: Манлайллын ур чадварт суралцах нь олон давуу талтай бөгөөд үүнд:

- **Та өөрийн давуу болон сул талуудыг хурдан таньж чадна:** Удирдагч болж еснө гэдэг нь юуг сайн хийж, сайжруулах шаардлагатай байж болох талбарт суралцах гэсэн үг бөгөөд ингэснээр та болон таны удирдаж буй хүмүүс таны боломжуудыг уншиж чадна. Таны удирдаж буй баг, төсөл, уулзалт эсвэл бусад байгууллага ихэвчлэн үргжүүлж, тусгадаг тул та өөрийн давуу болон сул талуудыг хурдан суралцах болно.
- **Та компанийн чиглэлийг илүү сайн ойлгож чадна:** Та илүү их манлайллын үүрэг хариуцлага хүлээх тусам компанийнхаа зорилгын талаар илүү ихийг мэдэх шаардлагатай болно. Танай компанийн хэтийн төлөвийн талаар илүү ихийг мэдэх нь байгууллага дотроо амжилтад хүрэх зорилгоо нэгтгэхэд тусална. Мөн өөртөө болон багийнхаа өмнө тодорхой зорилго тавихад тусална.¹⁴
- **Та багийнхаа урам зоригийг нэмэгдүүлэх боломжтой:** Үр дүнтэй удирдагч болох талаар илүү ихийг мэдэх нь таныг хүлээн зөвшөөрөх, урамшуулах, урамшуулах зэргээр багаа урамшуулах хамгийн сайн арга замыг олоход тусална. Хамт олондоо сайн урам зориг өгөх

¹² Мөн тэнд. 29 хуудас

¹³ What is leadership. <https://www.forbes.com/sites/kevinkruse/2013/04/09/what-is-leadership/?sh=28b>

¹⁴ [Harvard business essentials](#) leadership.

нь тэдний бүтээмж, урам зоригийг нэмэгдүүлж, зорилгodoо хурдан хүрэхэд тань тусална.

- **Та багаа нэгтгэж чадна:** Алсын хараа, зорилго тодорхой байвал манлайлал сайн ажилладаг. Яг юунд хүрэхийг хүсэж байгаагаа ойлгох нь танай багийн авах ёстой чиглэлийг тодорхойлоход тусална. Танай баг зорилго, түүнд хүрэх үүрэг хариуцлагаа тодорхой ойлгож чадвал амжилтад хүрэхийн тулд хамтран ажиллаж чадна.
- **Та илүү олон багийн гишүүдийг авч үлдэх боломжтой:** Та багаа хэрхэн сайн удирдахаа мэддэг бол тэд илүү их амжилтад хүрч, амжилтын мэдрэмжийг мэдрэх болно. Амжилттай байх нь багийнхаа сэтгэл санааг дээшлүүлэхэд туслах бөгөөд тэд тантай болон компанийтай хамт байх магадлал өндөр байх болно.
- **Үр дүнтэй удирдагчийн чанарууд:** Үр дүнтэй удирдагчид хэд хэдэн чанар, зөвлөн ур чадварыг эзэмшихийг хичээх ёстой. Гайхалтай удирдагч байна гэдэг нь танай баг, салбартай холбоотой техникийн өндөр ур чадвартай байх гэсэн үг юм. Та манлайлах чадвараа хөгжүүлэхэд анхаарлаа төвлөрүүлэхийн тулд хөгжүүлэх хэд хэдэн ур чадваруудыг энд оруулав.
- **Уян хатан байдал:** Та удирдаж байхдаа янз бүрийн хүмүүс, үйл явц, функцуудтэй тулгарах болно. Эдгээр элементүүд байнга өөрчлөгдөж болно. Хэзээ уян хатан байх шаардлагатайг мэдэх нь үйл явцыг оновчтой болгож, гишүүдийг өсөж дэвжих, шинэ ур чадвар эзэмшихэд нь туслах болно. Жишээлбэл, та багийн гишүүн шинэ даалгавар дээр амжилт гаргаж байгааг анзаарч магадгүй юм. Та тэдэнд анхны ажлаа дуусгахын оронд энэ шинэ ур чадвараа өргөжүүлэхэд нь туслах даалгавар өгч болно.
- **Эмпати:** Өрөвдөх сэтгэлийг дадлагажуулах нь эргэн тойрныхоо хүмүүсийг илүү сайн ойлгож, итгэлцлийг бий болгож, харилцааг хөгжүүлэхэд тусална. Тэдний ололт амжилт, сорилт бэрхшээлийг сонсоход бэлэн байгаарай, шаардлагатай бол хариу өгөх санал, зааварчилгааг санал болго. Багийнхаа үйлдлийг ойлгох нь зорилгodoо хүрэхийн тулд илүү сайн үйл явцыг хөгжүүлэхэд тусална.

СУДАЛГААНЫ ХЭСЭГ:Хувь хүний цаг төлөвлөлтөд мэдээллийн системийг ашиглах нь Хувь хүний менежментийн ур чадвар

Хувийн менежментийн ур чадвар нь ажлын бүтээмж, ажлын гүйцэтгэлийг нэмэгдүүлдэг. Үүний үр дүнд компаниуд ажилд авахдаа хувийн менежментийн онцгой ур чадвартай ажил горилогчдыг хайж байдаг. Хувийн удирдлагын ур чадвараа дээшлүүлснээр та илүү ажилд орох боломжтой болж, сонгосон салбartaа хамааралтай хэвээр үлдэх болно.

Хувийн менежмент эсвэл өөрийгөө удирдах чадвар нь таны мэдрэмж, бодол санаа, үйлдлээ хянах чадварыг агуулдаг. Энэ ур чадварын тусlamжтайгаар та бие даасан зорилго тавьж, түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээ авах боломжтой. Урт хугацаанд хувийн менежментийн ур чадвар нь таны карьерын замыг чиглүүлэхэд тусалдаг. Зорилгodoо хүрч, карьераа хөгжүүлэхэд шаардлагатай хувийн менежментийн ур чадварын¹⁵ зарим жишээг дурдвал:

¹⁵ Personal-management-skills. <https://ca.indeed.com/career-advice/career-development>.

Харилцааны чадвар нь бичгийн, аман, аман бус, харааны харилцааны ур чадвар гэсэн дөрвөн талыг хамардаг. Тэд таны захиасыг тодорхой илэрхийлэх, үүргээ гүйцэтгэхэд тань туслах чухал мэдээллийг хүлээн авахад тусалдаг тул харилцан үйлчлэл бүрийн чухал хэсэг юм. Таны үүрэг тодорхой хэмжээний багаар ажиллах чадвартай байдаг тул таны харилцааны ур чадвар үр дүнтэй хамтын ажиллагаанд чухал үүрэгтэй. Та багийн гишүүдээс мэдээлэл авах, даалгавраа хуваарилж, санал бодлоо хуваалцах, шинэ стратеги сурах боломжтой. Хүчирхэг манлайллагчид хэдэн мянга, тэр бүү хэл хэдэн сая хүнд нөлөөлж чадна¹⁶. Харилцааны ур чадвар нь таныг хамт олон, үйлчлүүлэгчид, үйлчлүүлэгчидтэйгээ мэргэжлийн хүчтэй харилцаа тогтооход тусалдаг. Харилцаа нь итгэл хүлээсэн холбоон дээр бий болж¹⁷ багын хамтын ажиллагаанд чухал үүрэг гүйцэтгэдэг.

Цаг төлөвлөлт нь карьераа амжилттай хөгжүүлэхэд чухал үүрэгтэй. Эдгээр ур чадварыг хөгжүүлэх эсвэл сайжруулах нь даалгавруудыг эрэмбэлэх, анхаарлаа төвлөрүүлэх, анхаарал сарниулах зүйлээс зайлсхийх боломжийг олгоно. Ингэснээр та эцсийн хугацаатай танилцах, шаардлагатай үед үүрэг даалгаврыг шилжүүлэх, компанийн зорилгод хүрэх боломжийг олгоно. Хийх ажлын жагсаалт хөтөлж, өдөр бүр хийх ёстой зүйлээ хянах нь цагаа зөв удирдах нэг арга юм. Хугацаанаас өмнө ажлаа дуусгахыг зорь, тиймээс танд засвар хийх хангалттай цаг байгаа бөгөөд яарах хэрэггүй.

Зохион байгуулалтын ур чадвар нь таны амьдралын бүхий л салбарт хэрэгжинэ. Эдгээр нь ажил мэргэжлийн өсөлтийн чухал хэсэг бөгөөд ажил олгогчдод өндөр үнэлэгддэг. Зохион байгуулалт сайтай хүмүүс цагаа илүү үр ашигтайгаар төлөвлөж, даалгавраа эрэмбэлж, үүрэг хариуцлагаа удирдаж, ажлын байран дээрээ үр дүнтэй ажиллах боломжтой.

Зорилго тавих нь юунд хүрэхийг зорьж байгаагаа тодорхой, тодорхой байдлаар тодорхойлох чадварыг агуулдаг. Энэ нь таны ажлын байр болон карьери хөгжилид чухал ач холбогдолтой бөгөөд энэ нь танд юу чухал болохыг тодорхойлж, тодорхой хугацаанд түүнд хүрэх алхмуудыг хийхэд тусалдаг. Энэ нь таныг урам зоригтой байлгаж, зорилгodoо хүрэхэд анхаарлаа төвлөрүүлдэг. Богино болон урт хугацааны зорилго тавих нь эхлэх сайхан арга юм.

Дарамт дор ажиллах чадвартай нь ажил олгогчид болон ажилд авах менежерүүд дарамт шахалт дор ажиллах чадвартай ажилчдыг хайж байдаг. Захирагч, захирагдагч нарын эрх мэдлийн тэнцвэртэй байдал алдагдаж, албан тушаалаа ашиглан хунд суртал гаргадаг дутагдлыг халж чадаагүйгээс арга барилаа зоригтой өөрчилж, шийдвэртэй ажиллахад том хаалт болсоор¹⁸ байна. Тэгвэл энэ үед тайван байж, стрессийн үед сайн ажиллах нь ажилдаа анхаарлаа төвлөрүүлэхэд тусална. Зохион байгуулалттай байх, олон ажил хийх, үр дүнтэй харилцах нь завгүй өдрүүд эсвэл хатуу хугацаатай ажиллахад өөрийгөө бэлтгэх бүх арга зам юм.

Олон талт байдал нь янз бүрийн чиглэлээр чадварлаг эсвэл мэдлэгтэй байхыг хэлнэ. Компаниуд одоо олон талт хүмүүсийг зайлшгүй шаардлагатай гэж үздэг тул тэд багт олон сонголтыг авчирдаг. Та олон талт байх үедээ шинэ багуудад амархан багтаж, тэдний гүйцэтгэлийг сайжруулж чадна.

¹⁶ Дэйл Карнеги. Манлайллын мастер. УБ., 2017 он. 24 дэх тал. Орч: Б.Төртүвшин

¹⁷ Мөн тэнд.

¹⁸ Ц.Цэрэндорж С.Цэрэндамба. Бидний менежмент. УБ., 2010 он. 187 дахь тал.

Багаар ажиллах нь хамт олонтойгоо сайн харилцаж, нэг зорилгын төлөө ажиллахын тулд ижил хариуцлага хүлээхийг хэлнэ. Үндсэндээ бие даасан үүрэг гүйцэтгэхэд тодорхой хэмжээний багаар ажиллах шаардлагатай байдаг тул эерэг хандлага, бусадтай хамтран ажиллах чадвар нь таны карьерын хөгжилд амин чухал¹⁹ юм. Компаниуд багийн тоглогчид болон хүмүүстэй харилцах чадвартай хүмүүсийг үнэлдэг.

Хариуцлага гэдэг нь өөрийн үйлдэл, бодол санааны төлөө хувийн хариуцлага хүлээхийг хэлнэ. Энэ нь таныг шийдвэрээ бодитойгоор үнэлж, итгэлтэйгээр шийдвэр гаргах боломжийг олгоно. Хариуцлагатай хүмүүс ч гэсэн найдвартай бөгөөд алдаанаасаа суралцаж, тасралтгүй сайжирч байгаадаа баяртай байдаг.

Өөрийгөө урамшуулах нь өөрийгөө урам зоригтой хүмүүс амжилтад хүрэх хүсэл тэмүүлэл, хүсэл тэмүүллээрээ өөрсдийгөө түлхэж, гаднын хүчин зүйлсийн эсрэг үр бүтээлтэй хэвээр байх болно. Энэ нь таны оролцож буй янз бүрийн төсөл, үйл ажиллагаанд ахиц дэвшил гаргах чухал тал юм.

Хувийн удирдлагын 10 ур чадвар, тэдгээрийг хэрхэн сайжруулах стратеги

Хувийн удирдлагын ур чадвар гэдэг нь хувийн зорилгодоо хүрэхийн тулд өөрийн цаг хугацаа, нөөц бололцоогоо төлөвлөх, зохион байгуулах, хянах чадвар юм. Олон хүмүүс хувийн менежментийн ур чадвараа дээшлүүлэх нь хувийн болон мэргэжлийн амьдралдаа илүү амжилтад хүрэхэд тусалдаг гэж үздэг.

Цаг төлөвлөлт гэдэг нь цагаа үр ашигтай, үр дүнтэй ашиглах чадвар юм. Үүнд зорилго тавих, хуваарь гаргах, түүнийгээ дагаж мөрдөх, цаг үрэхээс зайлсхийх зэрэг орно. Цагийн менежментийн ур чадвар нь таныг богино хугацаанд илүү их зүйлийг хийж бүтээхэд тусалдаг бөгөөд ингэснээр илүү үр бүтээлтэй, сэтгэл хангалаун амьдралыг бий болгоно. Цагийн менежмент бол зорилгодоо хүрэх, замдаа явах, хойшлуулахаас зайлсхийхэд тусалдаг²⁰ тул хувийн менежментийн чухал ур чадвар юм. Та цагаа үр дүнтэй удирдаж чадвал амьдралаа илүү хянаж, үр дүндээ сэтгэл хангалаун байх болно.

Зорилго тавих нь танд хамгийн чухал зүйлд цаг хугацаа, эрч хүчээ төвлөрүүлэх боломжийг олгодог тул хувийн менежментийн чухал ур чадвар юм. Зорилгоо тавиад явахад тодорхой төлөвлөгөөтэй байгаа учраас түүндээ хүрэх магадлал өндөр²¹ байдаг. Нэмж дурдахад зорилго тодорхойлох нь таныг тодорхой зорилгоо төлөвлөж байгаа тул урам зоригтой, замдаа явахад тусална. Үр дүнтэй зорилго тавихын тулд та тодорхой, бодитой, хүрч болохуйц байх хэрэгтэй. Таны зорилго бол "Би жингээ хасахыг хичээх болно" гэхээсээ илүү "Би зургадугаар сарын 1 гэхэд 10 кг турна" гэх мэт тодорхой байх ёстой. Тэд "Би марафон гүйх болно" гэхээсээ илүү "Би долоо хоногт гурван удаа 30 минут гүйх болно" гэх мэт бодитой байх ёстой. Мөн тэд "Би саятан болно" гэхээсээ илүү "Би энэ сард 500 доллар хэмнэнэ" гэх мэт амжилтад хүрэх ёстой.

Тэргүүлэх нь хувийн менежерүүдэд чухал ур чадвар бөгөөд учир нь энэ нь тэдэнд цаг зав, хүчээ хамгийн чухал ажлуудад төвлөрүүлэх боломжийг олгодог. Даалгавруудыг эрэмбэлэх үед менежерүүд даалгавраа бусдад хялбархан шилжүүлж, хамгийн чухал ажлыг дуусгахыг

¹⁹ Personal Management Skills. <https://climbtheladder.com/personal-management-skills/>

²⁰ The 7 Habits of Highly Effective People.

²¹ Management Skills. <https://www.healthknowledge.org.uk/>

баталгаажуулдаг. Даалгавруудыг эрэмбэлэхийн тулд менежерүүд эхлээд хамгийн чухал ажлуудыг тодорхойлох ёстай. Дараа нь тэд даалгавраа дуусгах хуваарь гаргаж болно. Эцэст нь тэд даалгавраа бусад даалгаж, тэдний явцыг хянах боломжтой. Даалгавруудыг эрэмбэлэх замаар менежерүүд хамгийн чухал ажлыг дуусгаж, тэдний цагийг үр дүнтэй ашиглаж байгаа эсэхийг баталгаажуулж чадна.

Эрчим хүчний хэмнэлт хийх олон арга байдаг. Үүний нэг нь: шавхагддаг нөөцийг ашигладаг эх үүсвэрийг, нөхөн сэргээгддэг эх үүсвэрээр солих, СЭХ-ний технологийг ашиглан хэрэглэгчид өөрсдийн хэрэглээний тодорхой хэсгийг цахилгаан эрчим хүч (ЦЭХ)-ээр хангах явдал юм.²⁹

2018 онд дэлхийн 146 улс сэргээгдэх эрчим хүчийг хөгжүүлэх үндэсний хөтөлбөрөө боловсруулсан. Үүний 57 улс нь 2050 он гэхэд эрчим хүчний нийт хэрэглээгээ 100% сэргээгдэх эрчим хүчээр хангах зорилгыг дэвшүүлсэн. Жишээ нь: 2014 онд Apple компани 100% СЭХ-д шилжихээр төлөвлөсөн. Тус компани 2016 хамгийн их буюу 393.3МВт

²⁹ А.Буянхишиг, М.Уранчимэг, Д.Пунсалмаа, Ч. Улам-Оргил “Эрчим хүчний хэмнэлтэнд сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэр ашиглах боломжийн судалгаа”

суурилагдсан хүчин чадал бүхий сэргээгдэх эрчим хүч үйлдвэрлэсэн бол 2018 онд компанийн бүх үйл ажиллагаа 100 хувь сэргээгдэх эрчим хүчээр хангагдсаныг өчигдөр зарласан³⁰.

Дэлхийн нийт эрчим хүчиний хангамжийн 26.5 хувийг сэргээгдэх эрчим хүчнээс үйлдвэрлэсэн нь өмнөх онтой харьцуулахад 7.2 хувиар өсжээ. Улс орны сэргээгдэх эрчим хүчиний хөгжлийн төлөвлөлтөөс харахад Австрали улс 2020 он гэхэд 45 ТВт.ц эрчмийг сэргээгдэх эх үүсвэрээс үйлдвэрлэх бол Япон 14 ГВт, 2030 онд 53 ГВт-д хүргэнэ гэсэн зорилттай байна.³¹

Манай улсын хувьд 2015 онд төрөөс эрчим хүчиний талаар баримтлах бодлогын баримт бичгийг баталсан. Энэ баримт бичигт эрчим хүчиний системийн суурилагдсан хүчин чадалд Сэргээгдэх эрчим хүчиний эзлэх хувь хэмжээг 2020 онд 20%, 2030 онд 30%-д хүргэхээр тусгасан³².

Дэлхий дахинд 2010 оноос хойш нарнаас эрчим хүч үйлдвэрлэх технологийн хөрөнгө оруулалтын зардал 73%-иар, салхин цахилгаан станцын технологийн үнэ 23%-р буурсан нь эрчим хүчиний хэмнэлтэд СЭХ-ний технологиудыг ашиглах эдийн засгийн хувьд үр ашигтай болж байгааг харуулж байна.

СУДАЛГААНЫ ХЭРЭГЛЭГДЭХҮҮН АРГА ЗҮЙ.

Судалгааны ажлын хүрээнд төслийг Конконсалтинг ХХК-н хийсэн. Баянзүрх дүүргийн 4-р хороонд байрших Их засаг ОУИС-ийн Хууль зүйн сургуулийн-II байр зураг төслийг ашиглна. Уг барилгын дотор цахилгаан хангамжийн зураг төслийг барилгын архитектор (БА) болон барилга бүтээц (ББ), цэвэр бохир, ус (ЦБУ), халаалт аргаар сэлгэлт (ХАС) зургийн даалгаврыг үндэслэн технологийн байгуулалт дээр хүчин төгөлдөр мөрдөж буй доорх стандартуудыг баримтлан гүйцэтгэв. Үүнд:

- ✚ БД 43-102-07 Орон сууц, олон нийтийн барилгын цахилгаан тоног төхөөрөмж төлөвлөх ба угсралт
- ✚ БНБД 23-02-08 Байгалийн ба зохиомол гэрэлтүүлэг
- ✚ БД 43-103-08 Барилга байгууламжийн аянга хамгаалалтын зураг төсөл зохиох заавар
- ✚ БД 43-101-03 Цахилгаан байгууламжийн дүрэм

Хүснэгт 1 0.4кВ-ын үндсэн тооцооны схем

Гэрлийн самбар (ГС)	Суурилагдсан хүчин чадал Рс[кВт]	Хүчин чадлын коэффициент	Тооцооны хүчин чадал Рт[кВт]
ГС-1	10.9	0.98	10.682
ГС-2	7.1	0.98	6.958
ГС-3	14.8	0.98	14.504
ГС-4	12.4	0.98	12.152
ГС-5	15.8	0.98	15.484


³⁰ <https://ikon.mn/n/19h9>, <https://www.apple.com/newsroom/2018/04/apple-now-globally-powered-by-100-percent-renewable-energy/>

³¹ theconversation.com

³² Сэргээгдэх эрчим хүчиний тухай хуульв.,(2015)

ГС-6	15.8	0.98	15.484
ГС-7	14.6	0.98	14.308
Хуваарилаг самбар АВР	17.8	0.98	17.444
Нийт	109.2		107.016

Барилгын зураг төсөл 34x18-ын харьцаатай 6-н давхар, гэрлийн долоон самбартай, ерөнхий оролтын 3 самбартай, нийлбэр суурилагдсан чадлын ачаалал 109.2кВт³³ байна. Сэргээгдэх эрчим хүч, нарны панелийг ашиглан барилгын нийт хэрэглээ болох 109.2кВт эрчим хүчний 16.5%-ийг буюу 18.1 кВт-ийг цахилгаан эрчим хүчээр ханган гэж үзсэн. Зураг 1 1-д 0.4кВ-ын үндсэн тооцооны бүдүүвч, технологийн байгуулалт харуулсан.



Зураг 2 0.4кВ-ын үндсэн тооцооны бүдүүвч, технологийн байгуулалт

Сэргээгдэх эрчим хүч (нарны панель, зайд хураагуур)-ийг тооцоо

Нар ээх хугацаа нь тухайн газар нутгийн байршилаас хамаараад өдөр бүр өөр өөр байдаг тул нарийвчилсан тооцоо хийхэд урт хугацааны хэмжилтийн өгөгдөл хэрэгтэй байдаг.

Улаанбаатар хотын барилгын дээвэрт суурилуулах боломжтой нарны цахилгаан үүсгүүрийн тооцооллыг Олон Сэргээгдэх Эрчим Хүчний Агентлаг (IRENA)-аас Сэргээгдэх эрчим хүчний дэлхийн атлас боловсруулах ажлын нэг хэсэг болсон цуврал вэб программуудын нэг болох “SolarCity” симуляторын программыг ашиглан тооцсон³⁴. Уг программаар айл өрх, аж ахуй нэгж болон үйлдвэрүүд дээвэр дээрээ нарны эрчим хүчний систем угсрах төлөвлөлт хийдэг, Бусад эрчим хүчний эх үүсвэртэй харьцуулан нарны системийг дээвэр дээрээ суурилуулснаар ямар хэмжээний санхүүгийн хэмнэлт, үр өгөөж гарахыг тооцоолж болдог.


Баянзүрх дүүрэгт байрших Их засаг ОУИС-ийн Хууль зүйн сургуулийн 2-р байр болох 6-н давхар 34x18-ын харьцаатай барилгыг сонгон авч судалгаа хийсэн. Тус сургуулийн цахилгааны тооцооны ачаалал нь 109.2кВт /EC-1 44.3 кВт, EC-2 45.3 кВт, EC-3 17.4 кВт/ ба ослын гэрэлтүүлгийн самбар, гэрэлтүүлгийн самбар /ГС-1, ГС-2, ГС-3 ГС-4, ГС-5, ГС-6, ГС-7/-ыг төлөвлөсөн байна. Сургуулийн эрчим хүчийг хэмнэхийн тул гэрэлтүүлгийг эрчим хүчний хэмнэлттэй ЛЕД чийдэн, нарны панелийг ашиглан цахилгааны хэрэглээний 18.1 кВт буюу 16.5% -г хангах тооцоо судалгааг хийлээ.

³³ Конконсалтинг ХХК-ийн зураг төсөл кк-08/20шифтэй

³⁴ <https://www.irena.org/-/media/Files/IRENA/Agency/Events/2021/Jun/SolarCity-simualtor---launch.pdf?la=en&hash=8F194AE191A1AA902870550210991333DAC42779>

Нарны панелийг сургуулийн дээр байршуулсан ба инвертер, тогтмол гүйдлийн хайрцаг, хувьсах гүйдлийн хайрцаг бусад тоноглолуудыг техникийн өнөөнд төлөвлөсөн.

Барилгын дээвэр дээр байрлуулсан нарны хураагуурын жилд үйлдвэрлэх цахилгаан эрчим хүчний хэмжээг “SOLARCITY” симуляторын программ хангамж ашиглан тооцсон.³⁵



Зураг 2 “SOLARCITY” симуляторын программ хангамжын тооцооллын үр дүн


Барилгын нийт хэрэглээ болох 109.2кВт эрчим хүчний 16.5%-ийг буюу 18.1 кВт-ийн цахилгаан эрчим хүчээр хангахаар тооцоолол хийсэн ба үр, дунд 18.3 кВт чадлыг гаргахад 150 Вт чадалтай 119 ширхэг нарны зайн хураагуурын суурилуулах бүрэн боломжтойн харагдаж байна.

СУДАЛГААНЫ АЖЛЫН ҮР ДҮН

Баянзүрх дүүрэгт байрших Их засаг ОУИС-ийн Хууль зүйн сургуулийн 2-р байр болох 6-н давхар 34x18-ын харьцаатай барилгыг сонгон нарны зайн үүсгүүрийн тооцооллыг хийсэн

Барилгын дээвэр дээр байрлуулсан 18.1 кВт чадалтай нарны үүсгүүрийн жилд үйлдвэрлэх цахилгаан эрчим хүчний хэмжээ 21.8 сая кВт.ц байна. Уг барилга дээр нийт 18.3 кВт чадлыг гаргахад 150 Вт чадалтай 119 ширхэг нарны панель хэрэгтэй ба ашиглалтын хугацаатай 20 жил. Нарны зайн үүсгүүрийг суурилуулах ба анхны хөрөнгө оруулалт 68062764 төгрөг байна.

³⁵ <https://solarcity.irena.org>



Зураг 3 Нарны зайн хураагуурын цахилгаан эрчим хүчиний (ЦЭХ) үйлдвэрлэлийн хэмжээ³⁶

Дээрх тооцоолол нарны зайн хураагуурын цахилгаан эрчим хүчиний үйлдвэрлэлийг жилээр буюу 365 хоногоор болон сараар задлан харуулсан байна. Монгол улсын нарны арвин их нөөцтэй улсад тооцогддог ба 2,3,4,8,9,10 саруудад нарны эрчим хүчиний үйлдвэрлэл өндөр байгааг харж болно. Эрчим хүчиний хэрэглээ 3 сард хамгийн өндөр 3590.6 kWt.cag бол хоногт хамгийн ихдээ 148.8 kWt.cag цахилгаан эрчим хүчийг үйлдвэрлэнэ. 10 сард 3385.6 kWt.cag бол хоногт хамгийн их 152.4 kWt.cag цахилгаан эрчим хүчийг үйлдвэрлэнэ. 5-7 сард хамгийн бага 1401 kWt.cag цэх-ийг үйлдвэрлэх юм. Барилгын цахилгаан хангамжид сэргээгдэх болон төвийн эрчим хүчийг хослуулан ашиглах үеийн эдийн засгийн үр ашгийн тооцоог дараах хүснэгтэд үзүүлсэн.

Хүснэгт 2

Cap	Сард үйлдвэрлэх ЦЭХ/kWt.cag/	1kWt цаг ЦЭХ үнэ	Сард үйлдвэрлэсэн цэх-н үнэ
1	1546.637	187₮	289221.194₮
2	2652.758	187₮	496065.709₮
3	3590.633	187₮	671448.408₮
4	2170.892	187₮	405956.767₮
5	1476.691	187₮	276141.142₮
6	1329.066	300₮ ³⁷	398719.86₮
7	1399.075	300₮	419722.38₮
8	1685.068	300₮	505520.4₮
9	2828.826	187₮	528990.462₮
10	3385.598	187₮	633106.751₮
11	1858.133	187₮	347470.908₮
12	1107.121	187₮	207031.702₮
Жилд үйлдвэрлэсэн нийт цэх-н үнэ	25030.5		5179395.68₮
Нарны панелийн хөрөнгө оруулалт			68062764₮
Хөрөнгө оруулалтын 50% сургууль төлнө			34031382₮
Ногоон зээлийн хүү			3%
Энгийн эргэн төлөгдөх хугацаа			6.6 жил

³⁶ <https://solarcity.irena.org>

³⁷ Нарны эрчим хүчиний үүсгүүрээр үйлдвэрлэж нийлүүлэх 1 kWt.c цахилгаан эрчим хүчийг 0.15-0.18 ам. доллар /өнөөгийн байдлаар 300-360 төгрөг/.

Өгөөжийн дотоод хувь	13.4%
----------------------	-------

18.3 кВт-н хүчин чадалтай 119 ширхэг, 20 жилийн ашиглалтын хугацаатай, нарны зайн үүсгүүрийг суурилуулах ба анхны хөрөнгө оруулалт 68062764 төгрөг, сургууль өөрийн төсвөөс гаргах ба үлдсэн 50%, 34031382 төгрөгийг ногоон зээлээс санхүүжин гэж үзсэн. Жилд 5179395.7 төгрөгийн, 25030.5 кВт цаг цахилгаан эрчим хүчийг үйлдвэрлэх ба 6.6 жилийн дотор хөрөнгө оруулалтаа эргэн төлнө. Өгөөжийн дотоод хувь 13.4-тай эдийн засгийн хувьд үр өгөөжтэй болох нь харагдаж байна.

- ✓ Нарны зайн хураагуур (панелийг) суурилуулснаар 29 тонн (CO₂) хүлэмжийн хийг ялгаруулалтыг бууруулах
- ✓ PM2.5-н 4.4 кг тоосонцрыг агаарт цацахаас сэргийлнэ.
- ✓ 1275 ширхэг мод тарьсантай тэнцэхүйц байгаль орчинд эерэг нөлөөтэй.

ДҮГНЭЛТ

Баянзүрх дүүрэгт байрших Их засаг ОУИС-ийн Хууль зүйн сургуулийн 2-р байр болох 6-н давхар 34x18-ын харьцаатай барилгыг сонгон нарны зайн үүсгүүрийн тооцооллыг хийсэн. 18.3 кВт-н хүчин чадалтай 119 ширхэг, 20 жилийн ашиглалтын хугацаатай, нарны зайн үүсгүүрийг суурилуулах ба анхны хөрөнгө оруулалт 68062764 төгрөг байна.

Жилд 5179395.7 төгрөгийн, 25030.5 кВт цаг цахилгаан эрчим хүчийг үйлдвэрлэх ба 6.6 жилийн дотор хөрөнгө оруулалтаа эргэн төлнө. Өгөөжийн дотоод хувь 13.4-тай байна.

Уламжлалт эх үүсвэрээс цахилгаан эрчим хүч үйлдвэрлэх нь хямд өртөгтэй байдаг, үүний цаанаа байгаль экологийн асуудал байнга дагалдаж байдаг.

Жишээ нь: ³⁸(CO₂) нь агаар мандлаас бүрэн арилтлаа 30-95 жил зарцуулдаг ба тал хувь нь бүтэн зуунд агаар мандлаас арилдаг бол 20% нь олон зуун жилд агаар мандалд арилалгүй тогтдог. Тэгвэл уг барилга дээр 18.3 кВт-н хүчин чадалтай 119 ширхэг нарны зайн хураагуурын суурилуулж сэргээгдэх эрчим хүчнийг хэрэглэснээр

- ✓ Нарны зайн хураагуур (панелийг) суурилуулснаар 29 тонн (CO₂) хүлэмжийн хийг ялгаруулалтыг бууруулах
- ✓ PM2.5-н 4.4 кг тоосон цорыг агаарт цацахаас сэргийлнэ.
- ✓ 1275 ширхэг мод тарьсантай тэнцэхүйц байгаль орчинд эерэг нөлөөтэй.

Дулааны 4-р цахилгаан станц 1кВт цахилгаан эрчим хүчнийг үйлдвэрлэхэд 541гр, дулааныг үйлдвэрлэхэд 296гр нүүрс шатаадаг ба гэрийн угаалгын машиныг 1 цаг ажиллуулахад 1.1 кг түлш шатаадаг. Энэ нь байгалийн шавхагддаг нөөц, баялаг бөгөөд эрчим хүчийг хэмнэх, сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрүүдийг ашиглах хэрэгтэй юм.

³⁸ <https://solarmeansbusiness.com/>

АШИГЛАСАН НОМ ЗҮЙ

1. 3.Цэрэндорж, Ц. Эрдэнэтуяа “ Сэргээгдэх эрчим хүчний хэрэглээ ба энергийн хурийн тлуур ” Улаанбаатар хот: Монгол. 44ху, 101-131ху
2. Монгол Улсын ногоон эрчим хүчний систем, эрчим хүчний хэмнэлт, үр ашгийн хөгжил 17ху
3. Д.Содномдорж “Цахилгаан эрчим хүчний хэмнэлт” нэг сэдэвт бүтээл.Монгол. 77х
4. А.Буянхишиг, М.Уранчимэг, Д.Пунсалмаа, Ч. Улам-Оргил “Эрчим хүчний хэмнэлтэнд сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэр ашиглах боломжийн судалгаа” ШУТИС, ЭШБ 2019 он Улаанбаатар хот: Монгол.
5. IRENA Renewable energy report., (2019)
6. IRENA Renewable energy report., (2020)
7. Сэргээгдэх эрчим хүчний тухай хууль., (2015)
8. Төрөөс эрчим хүчний талаар баримтлах бодлогын баримт бичиг., (2015),
9. Эрчим хүчний статистик үзүүлэлтүүд (2014-2020)., ЭХЗХ-ны эмхэтгэл [3]: 8-16
10. <https://solarcity.irena.org>
11. <https://solarmeanbusiness.com/>
12. <https://globalsolaratlas.info/>
13. <https://news.energysage.com/>

ДИЖИТАЛ ЭДИЙН ЗАСАГ ДАХЬ ТАТВАРЫН АЮУЛГҮЙ БАЙДАЛ

Г.Алтанзаяа^{1a}

¹Мандах Их Сургууль, Бүртгэл шинжилгээний тэнхим, Зөвлөх багш

[aaltanzaya99@gmail.com](mailto:altanzaya99@gmail.com)

ХУРААНГҮЙ

Дижитал эдийн засаг нь асуудлуудаа шинэ технологийн тусламжтайгаар шийдээж буй дижитал тооцооллын технологид суурисан эдийн засгийг хэлэх буюу уламжлалт эдийн засгаас илүү хурдан, хүртээмжтэй, хямд бизнесийн загваруудаар ажс үйлдвэрийн 4-р хувьсал руу хөтмөж байна.

Технологийн тусламжтайгаар компаниуд аль нэг улсад биет дэд бүтэц байгуулахгүйгээр тухайн улсын эдийн засагт оролцож, хэрэглэгчдэд алсаас үйлчилгээ үзүүлж, орлого олох болсон нь уламжлалт нутаг дэвсгэрийн зарчмын татвар ногдуулалт өөрчлөгдөж татварын аюулгүй байдал, орчин үеийн бизнесийн орчны татвар ногдуулалтын шинэ ойлголтууд бий болоод байна.

Дижитал эдийн засгийг татваржуулах нь татвар(төрийн)ын аюулгүй байдал, хүн төрөлхтний шударга байдалтай шууд холбогдож буй тул олон улсын хүрээнд ТСГАШ(BEPS) төслийг хэрэгжүүлэх шийдэлд улс орнууд нэгдээж байгаа нь татварын аюулгүй байдлаа хангах үйл хэрэг юм. Татварын аюулгүй байдал, дижитал эдийн засгийн хүрээ, бизнесийн ангилал, гүйлгээний элемент, татварын зарчим, татваржуулахад чиглэсэн олон улсын хандлагад уг ажил чиглэж буй болно.

Түлхүүр үг: Дижитал үйлчилгээ, Татваржуулалт, Тулгуур 1 ба 2, BEPS, ТСГАШ

ОРШИЛ

Дижитал виртуал ертөнц нь материаллаг ертөнцөд улам бүр бодитойгоор нөлөөлж байна. Технологийн хувьсгал менежментийн онолд өөрчлөлт авчирч, шинэ дижитал орчинд үнэ цэнийг бүрдүүлэх соёл практик болж, төрийн болон хүмүүс, бүлэг хоорондын харилцаанд илрэлээ олоод байна. Энэ бүхний үр дүнд одоо болон ирээдүйд татварын аюулгүй байдлыг хэрхэн хангах уу гэдэгт судлаачид анхаарлаа хандуулж байна. Татварын аюулгүй байдлыг хэрхэн хангах гэдэгт улс орнуудын төрийн бодлого, татварын албад үйл ажиллагаагаа өөрчлөх шаардлагатай болсон. Хууль тогтоох байгууллага, гүйцэтгэх эрх бүхий байгууллага, татвар төлөгчид, банкны системийн болон бусад оролцогчдод бодитойгоор үүсч буй татварын аюулгүй байдлыг хэрхэн хангах сорилтой тулгарсан. Иймээс дижитал эдийн засгийн нөхцөлд татварын аюулгүй байдал аа хэрхэн хангах, эдийн засгийн ямар гүйлгээнд, хаана, хэнд татвар ногдуулах уу гэдгийг шийдвэрлэх ЭЗХАХБ-аас хэрэгжүүлж буй ТСГАШ төслийн хүрээнд гарсан баримт бичиг, арга зүйг дагахад улс орнууд нэгдэж байна.

Татварын аюулгүй байдал

Дижитал эдийн засгийн хөгжил нь татварын аюулгүй байдлын асуудалтай салшгүй холбоотой. Судлаачид "татварын аюулгүй байдал" гэсэн нэр томъёог үндэсний аюулгүй байдлын нэг хэсэг болох аюулгүй байдлын төрлүүдийн түвшин(мэдээлэл, нийгэм, эдийн засаг, цэрэг арми, санхүү, гэх мэт)-тэй холбож авч үзэж байна³⁹ (Невзорова, Киреенко, Скляров, 2017). Татварын аюулгүй байдлын хамрах хүрээ, уялдааг дараах схемээр харуулжээ⁴⁰.



Зураг 1 *Татварын аюулгүй байдал*.

(Lyudmila V. Sanina, Oksana V. Antipina, Shuiyao Xu, Threats to tax security in the digital economy)

Дижиталчлалын хүрээнд аль улсад бүтээгдэхүүн, үйлчилгээг үйлдвэрлэсэн, хаанаас худалдан авсан зэргийг хянах нь илүү төвөгтэй болсон. Иймээс татвараас зайлсхийх, татварын орлого буурах, татварын гэмт хэрэг, зөрчилдөөн үүсэх нөхцөл байдал бий болсон нь улс орны аюулгүй байдалд нөлөөлж буйг судалгаагаар харуулжээ.

Эдийн засгийн гүйлгээний дижитал элемент

Дижитал эдийн засаг гэдэг нь дижитал технологид суурилсан эдийн засгийг хэлэх ба хүмүүс үүнийг интернет болон дэлхийн сүлжээнд суурилсан зах зээлээр дамжуулан бизнес эрхлэхийг ойлгодог.⁴¹

Дижитал эдийн засгийг тодорхойлохын тулд дижитал технологийг ашиглахтай холбоотой эдийн засгийн гүйлгээний элементүүдийг ойлгох нь чухал юм⁴². Татварт хамрагддаггүй ийм дижитал элементүүд байгаа эсэхээс хамааран дижитал гүйлгээ болон дижитал бизнесийн загваруудыг татварын зорилгоор ангилах, ойлгох болоод байгаа.

Дата кодчилолын технологийг ашигладаг аливаа зүйлийг дижитал гэж нэрлэх бөгөөд энэ нь дэлхий даяар өгөгдлийг бодит цаг хугацаанд дамжуулах боломжийг олгож байна. Энэхүү өгөгдөл кодлох технологид тулгуурласан эдийн засгийн гүйлгээний аливаа элементийг дижитал элемент гэж үзнэ (тоон харилцаа холбоо, дижитал контент, дижитал автоматжуулалт, дижитал түгээлт, дижитал төлбөр)⁴³.

³⁹ Threats to tax security in the digital economy.

https://www.researchgate.net/publication/347393704_Threats_To_Tax_Security_In_The_Digital_Economy

⁴⁰ Lyudmila V. Sanina, Oksana V. Antipina, Shuiyao Xu, Threats to tax security in the digital economy.

⁴¹ Some Precepts of the Digital Economy. Productivity, Innovation & Technology eJournal. Social Science Research Network (SSRN). Accessed 27 January 2020.

⁴² Cristian Óliver Lucas-Mas and Raúl Félix Junquera-Varela. Tax Theory Applied to the Digital Economy: A Proposal for a Digital Data Tax and a Global Internet Tax Agency. World Bank Group

⁴³ Cristian Óliver Lucas-Mas and Raúl Félix Junquera-Varela. Tax Theory Applied to the Digital Economy: A Proposal for a Digital Data Tax and a Global Internet Tax Agency. World Bank Group

Дижитал контент, дижитал түгээлт, дижитал автоматжуулалт зэрэг татваргүй дижитал элементүүд нь хоорондоо холбогдож, хамтран ажиллаж дижитал бизнесийн загвар болж байна. Жишээлбэл, дижитал контентыг зөвхөн дижитал түгээлтээр дамжуулан онлайнаар хүргэх боломжтой бөгөөд дижитал контентыг нийлүүлэх, түүнд хандах хандалтыг ихэвчлэн автоматжуулалтаар шийдвэрлэж байна. Дижитал түгээлт нь интернетийг дамжуулах суваг болгон ашиглах бөгөөд энэ нь дижитал харилцааны элемент юм.

Хүснэгт 1-д эдийн засгийн гүйлгээний ангилал, бизнесийн загвар, дижитал элементүүдийн төрлийн хамаарлыг авч үзье. (✓ хамааралтай, x хамааралгүй)

Хүснэгт 1 Эдийн засгийн гүйлгээний дижитал элемент

Гүйлгээний ангилал ба тэдгээрийн бизнесийн загварын төрөл	Дижитал элементийн төрөл				
	Харилцана холбоо	Контент	Автоматжуулалт	Түгээлт	Төлбөр
Уламжлалт гүйлгээ ба бизнесийн загвар					
Биет төлбөрийн хэрэгслээр төлсөн бараа, үйлчилгээг биечлэн нийлүүлэхтэй холбоотой гүйлгээ (хүүхэд асрагч, гудамжны худалдаачид, зах, бэлэн мөнгөний худалдаа)	X	X	X	X	X
Дижитал гүйлгээ ба бизнесийн загвар					
Дижитал төлбөрийн аргыг ашиглан төлсөн бараа, үйлчилгээний биет нийлүүлэлттэй холбоотой биечлэн хийсэн гүйлгээ (зээлийн картын борлуулалт, онлайн хэрэглээний төлбөрийн төлбөр)	X	X	X	X	✓
Бараа, үйлчилгээний бодит нийлүүлэлттэй холбоотой онлайн гүйлгээг бодит төлбөрийн аргаар төлдөг (Craigslist гэх мэт зар сурталчилгааны үнэ төлбөргүй байршуулах сайтууд; онлайнаар бараагаа захиалах бодит жижиглэнгийн худалдааны вэбсайтууд)	✓	X	X	X	X
Дижитал төлбөрийн хэрэгслээр төлсөн бараа, үйлчилгээний бодит нийлүүлэлттэй холбоотой онлайн гүйлгээ (Amazon эсвэл eBay гэх мэт онлайн зах зээл; Uber гэх мэт онлайн тээврийн үйлчилгээ; Uber Eats гэх мэт онлайн хоол хүргэх үйлчилгээ; Marriott гэх мэт зочид буудлын онлайн захиалга; Zara гэх мэт жижиглэнгийн худалдааны онлайн дэлгүүрүүд)	✓	X	X	X	✓
Татварын орлогыг алдагдуулдаг дижитал гүйлгээ ба бизнесийн загвар					
Дижитал автоматжуулсан, дижитал байдлаар түгээсэн, дижитал төлбөрийн хэрэгслээр төлдөг (Amazon гэх мэт онлайн зах зээл; Apple iTunes Store эсвэл Amazon Kindle Store гэх мэт дижитал контентын онлайн жижиглэн худалдаачид; Microsoft Store гэх мэт дижитал түгээлтийн платформууд); Netflix эсвэл Spotify зэрэг дижитал медиа үйлчилгээ; Google гэх мэт вэб хайлтын системүүд)	✓	✓	✓	✓	✓

Эх сурвалж: Cristian Oliver Lucas-Mas and Raúl Félix Junquera-Varela. Tax Theory Applied to the Digital Economy: A Proposal for a Digital Data Tax and a Global Internet Tax Agency. World Bank Group P21.

Татварын үүднээс бол ийм дижитал орцыг олж авах, боловсруулахад гарсан бүх зардлыг (дижитал контентыг үнэ төлбөргүй нийлүүлэх, техникийн платформ боловсруулах, автоматжуулалтын технологи) гүйлгээний татвар ногдуулах орлогыг тодорхойлохдоо хасах ёстой.

Хүснэгт 2-т татварт хамрагдахгүй дижитал бизнесийн загварын ангиллыг харуулж байна. Интернет компаниуд ихэвчлэн өөр өөр бизнес загвараар хэд хэдэн бизнесийн үйл ажиллагааг нэгэн зэрэг хөгжүүлж хэрэгжүүлж болно.

Хүснэгт 2 Дижитал бизнесийн загварын ангилал

Татварын орлого алдагдуулж буй дижитал бизнесийн загварын төрөл (жишээ)	Бизнесийн санааг мөнгөжүүлэх, хэрэглэгчийн саналыг авах дижитал гүйлгээ (ижил татвар төлөгч).
<p>Агуулгатай холбоотой</p> <ol style="list-style-type: none"> Хэрэглэгчийн бус дижитал контентын худалдаа (Kindle Store, Apple iTunes Store) Хэрэглэгчийн бус дижитал контентын лиценз (Microsoft, IBM, Cisco, Oracle) Хэрэглэгчийн бус дижитал контентыг захиалах (Netflix, Spotify, Amazon Prime) <p>Зохицуулалттай үйл ажиллагаа</p> <ol style="list-style-type: none"> Виртуал банк (First Direct, ING Direct, Revolut) Виртуал даатгал (ZhongAn, Bowtie даатгал) Онлайн мөрийтэй тоглоом (Bet365, Bwin, Betfair, 888) <p>Олон талт платформ</p> <ol style="list-style-type: none"> Онлайн цахим худалдааны зах зээл (Amazon, Uber, Airbnb, Booking, eBay, Alibaba, Tencent, Expedia, crowdfunding платформ, онлайн покер) <p>Хэрэглэгчтэй холбоотой</p> <ol style="list-style-type: none"> Хэрэглэгчтэй холбоотой өгөгдөл болон хэрэглэгчийн оруулсан тоон контентыг худалдах (Facebook, Instagram, Twitter) Хэрэглэгчдэд чиглэсэн онлайн сурталчилгаа (Google Ads, Amazon, LinkedIn, Alibaba, YouTube, Facebook, Reddit) Дижитал бизнесийн борлуулалтын нэг хэсэг болох хэрэглэгчтэй холбоотой сайн санааны борлуулалт (бизнесээс гарах стратеги) (Instagram, LinkedIn, WhatsApp, Skype, Waze, YouTube, Fitbit) 	<p>1.1. Дижитал контентыг дижитал автоматжуулж, дижитал хэлбэрээр түгээх онлайн худалдаа</p> <p>2.1. Дижитал контентыг ашиглах онлайн лиценз (програм хангамжийн эцсийн хэрэглэгч лиценз) тусгай зөвшөөрлийн төлбөр</p> <p>3.1. Дижитал контент болон бусад зүйлд хандах онлайн захиалгын хураамж, ашиг тус</p> <p>4.1. Дижитал сувгаар алсаас жижиглэнгийн банкны үйлчилгээг санал болгодог зөвхөн интернет банк</p> <p>5.1. Жижиглэнгийн даатгалыг санал болгодог зөвхөн интернетийн даатгалын компани дижитал сувгаар дамжуулан үйлчилгээ үзүүлнэ</p> <p>6.1. Онлайн мөрийтэй тоглоом, бооцооны үйл ажиллагаа шууд хэрэглэгч болон вэбсайтын хооронд</p> <p>7.1. Олон талт платформд үнэгүй онлайн нэвтрэх</p> <p>7.2. Дижитал платформын оператор зуучлагчийн үүрэг гүйцэтгэж, төлбөр авах, дижитал платформын хэрэглэгчдийн хооронд хийгдсэн арилжаа бүрийн гүйлгээний хураамж</p> <p>8.1. Хуулийн дагуу дижитал контентод онлайннаар хандах</p> <p>хэрэглэгчийн мэдээлэл болон контентыг худалдах эрх</p> <p>8.2. Хэрэглэгчтэй холбоотой өгөгдөл болон дижитал контентын худалдаа</p> <p>9.1. Хэрэглэгчийн өгөгдөл, контентыг ашиглах хууль ёсны эрхийн хариуд дижитал контентод онлайннаар хандах</p> <p>9.2. Хэрэглэгчдэд чиглэсэн онлайн сурталчилгааны борлуулалт</p> <p>10.1. Хуулийн дагуу дижитал контентод онлайннаар хандах</p> <p>хэрэглэгчийн суурь, хэрэглэгчтэй холбоотой өгөгдөл, хэрэглэгчийн үүсгэсэн дижитал контентоос ашиг хүргэх эрх</p> <p>10.2. Хэрэглэгчтэй холбоотой гүүдвилээр үнэ цэнэ нь нэмэгддэг дижитал бизнесийн борлуулалт</p>

Эх сурвалж: Cristian Óliver Lucas-Mas and Raúl Félix Junquera-Varela. Tax Theory Applied to the Digital Economy: A Proposal for a Digital Data Tax and a Global Internet Tax Agency. World Bank Group P22-23.


Эдийн засгийн гүйлгээний дижитал элементүүдийг танин мэдэх нь татварт хамрагдахгүй хүрээг тогтоох, тэдгээрийг татварт хамруулах бодлогын шийдэл гаргахад тус дөхөмтэй юм.

Дижитал эдийн засагт татвар ногдуулах зарчим

Татварын зарчмууд нь татварын тогтолцоог хөгжүүлэхэд удирдан чиглүүлдэг уламжлалт хэрэгсэл юм. Татварын зарчмууд дижитал эдийн засгийн татварт уламжлалт эдийн засагтай яг ижил нөлөөлөхгүй. Жишээ нь, босоо тэгш байдлын зарчим хувь хүний орлогын албан татварт

илүү тохиромжтой бол дижитал эдийн засгийн татвар ногдуулах объект болох бизнесийн татвар ногдуулалтад тийм ч тохиромжтой биш байж болно. Дижитал эдийн засгийг татваржуулалтыг татварын зарчимтай холбон шинжилгээ хийсэн байна⁴⁴

Дижитал технологийн хэрэглээ нь уламжлалт бизнесийн загвараас ялгаатай бизнесийн шинэ загваруудыг бий болгох боломжийг олгосон боловч дижитал элементүүдийн нөлөөлөл нь уламжлалт бизнестэй ижил төстэй биш тул яг адил зарчим үйлчлэх боломжгүй гэж үзжээ. Татварын орлогыг тасалдуулахад нөлөөлж буй дижитал бизнесийн загварт хэрэглэх зарчмуудын харилцан үйлчлэлийг доор зургаар нэгтгэн харуулав.



Зураг 2 Дижитал бизнесийн загварт хэрэглэх татварын зарчмын харилцан үйлчлэл.

(Эх сурвалж: Cristian Oliver Lucas-Mas and Raúl Félix Junquera-Varela. Tax Theory Applied to the Digital Economy: A Proposal for a Digital Data Tax and a Global Internet Tax Agency. World Bank Group P44)

Дижитал эдийн засгийг татварын зорилгоор уламжлалт эдийн засгаас тусад нь ялгахад хэцүү, боломжгүй юм. Дижитал эдийн засгийн бизнес загварууд нь татварын үүднээс авч үзэх боломжтой ба татвар ногдуулах шинж чанаруудыг агуулдаг⁴⁵ гэдэгт судлаачид нэгдсэн байна. Уламжлалт бизнесийн загварт татвар ногдуулдаг бол дижитал бизнесийн загварт ижил татвар ногдуулах ёстой. Уламжлалт бизнесийн загварт татвар ногдуулахгүй бол дижитал бизнесийн загварт татвар ногдуулах ёсгүй гэсэн зарчмыг судлаачид тодорхойлсон⁴⁶ байна.

Бизнесийн загварууд нь ижил төстэй эдийн засгийн нөхцөл байдалд ямар үр өгөөж хүртэж байгаа эсэхийг үнэлэхэд ашиг тусын зарчмыг ашиглах ёстой. Өгөөж байхгүй тохиолдолд татварын бүрэн эрхт байдлын үндсэн дээр оршин суугаа газрын зарчмаар татвар ногдуулахаас бусад үед татвар ногдуулах ёсгүй гэсэн үзлийг тодорхойлжээ⁴⁷.

⁴⁴ Эх сурвалж: Cristian Oliver Lucas-Mas and Raúl Félix Junquera-Varela. Tax Theory Applied to the Digital Economy: A Proposal for a Digital Data Tax and a Global Internet Tax Agency. World Bank Group P29-44.

⁴⁵ Addressing the Tax Challenges of the Digital Economy ACTION 1: 2015 Final Report. P11.

⁴⁶ Алтанзаяа, Г. (2020). Татвар, Улаанбаатар хот: Монгол. x352-371

⁴⁷ Cristian Oliver Lucas-Mas and Raúl Félix Junquera-Varela. Tax Theory Applied to the Digital Economy: A Proposal for a Digital Data Tax and a Global Internet Tax Agency. World Bank Group

Дижитал эдийн засагт чиглэсэн татварын арга хэмжээ (ЭЗХАХБ, EX)

Хүртээмжстэй Хүрээ, Түлгүүр 1 ба 2 санал (Inclusive Framework, pillar 1, 2)

Тодорхой бизнес эрхлэгчдэд ашиг хуваарилах шинэ дүрмийг тодорхойлсон болно. Ашгийг хялбаршуулсан, томъёолсон зарчмуудаар хуваарилдаг бөгөөд үүнд хуваарилалт ба маркетингийн чиг үүргийн суурь өгөөж, мөн бүлгийн нийт үлдэгдэл ашгийн хувь орно.

Дижитал үйлчилгээний орлогоос татварыг суутгах

Энэ нь дижитал үйлчилгээний орлогыг оршин суугч бус этгээдэд төлөх үед татвар суутгалтыг (эсвэл цуглуулах механизмын дагуу) хэрэгжүүлнэ. Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр, хүү, ногдол ашгийн төлбөрт татварыг суутгана.

Дижитал төлөөний газар

Энэ нь татварын харьяаллын дагуу эдийн засагтайгаа тогтвортой харилцан уялдаатай оршин суугч бус бизнес эрхлэгчдэд татвар ногдуулах эрхийг олгоно. Энэ арга нь тухайн улс(харьяалал)д бизнес эрхэлдэггүй байсан ч хамаатай. Жишээлбэл, тухайн бизнес нь харьяаллын хүрээнд борлуулалт эсвэл хэрэглэгчийн оролцоо хангалттай түвшинд байвал татвар ногдуулах боломжтой гэж үзнэ.

Дижитал үйлчилгээний татвар (DST- digital service tax)

Энэ нь онлайн зар сурталчилгаа, зуучлагчийн үйлчилгээ зэрэг тодорхой дижитал үйлчилгээнээс орлого олдог бизнес эрхлэгчдэд шууд татвар ногдуулахыг эрмэлздэг. Дэлхийн дижитал үйлчилгээний орлогыг шууд харьяаллын дагуу хэрэглэгчдийн тоо, үзэл бодол (зар сурталчилгааны үйлчилгээ) эсвэл гүйлгээ (зуучлагчийн үйлчилгээ) дээр үндэслэн хуваарилдаг. Дижитал үйлчилгээний татварыг хэрэгжүүлж буй олон улс байгаа ба Зар суртачилгаа, Цахим худалдаа, Дата дамжуулал ... зэргийг татварын объект болгон хэрэгжүүлж байна.

Дижитал эдийн засгийн татваржуулах үйл ажиллагаа

1998 онд Оттавагийн Сайд нарын бага хурлаар ЭЗХАХБ-аас “Хил хязгааргүй ертөнц: Цахим худалдааны чадавхийг ухамсарлах нь”⁴⁸ сэдэвт баримт бичиг баталжээ. Энэ баримт бичиг нь засгийн газруудад цахим худалдаанд татвар ногдуулахад баримтлах зарчмуудыг тусгасан бөгөөд цахим худалдааг уламжлалт арилжаатай адилтгаж үзэх ёстойг дурьдаад ялгаварлахаас зайлсхийх хэрэгтэйг цохон тэмдэглэжээ. 2001 онд ЭЗХАХБ нь татварын гэрээний үзэл баримтлалыг цахим худалдаанд ашиглах, орлогыг цахим худалдааны гүйлгээнд оролцдог төлөөний газарт хуваарилах зэрэг гол асуудлуудад шууд татвар ногдуулах чиглэлээ багасгасан, харин хэрэглээний албан татварыг цахим худалдаанд хэрхэн ашиглах талаарх бодлогын ажил хийгджээ⁴⁹.

Дижитал технологийг хөгжүүлэх, дэлгэрүүлэх нь дэлхийн эдийн засагт дижиталчлалын давалгааг хөгжүүлсэн ба бидний өдөр тутмын амьдралд эрс өөрчлөлт авчирч, нийгмийн сайн сайхан байдалд нөлөөлөхийн зэрэгцээ олон жилийн турш хэрэгжиж ирсэн хууль эрх зүй, зохицуулалтын дэглэмд өөрчлөлт гарсан. Аж ахуйн нэгжийн орлогод албан татвар ногдуулах

⁴⁸ chrome-extension://efaidnbmnnibpcajpcgclefindmkaj/https://one.oecd.org/document/SG/EC(98)14/FINAL/en/pdf

⁴⁹ Cristian Óliver Lucas-Mas and Raúl Félix Junquera-Varela. Tax Theory Applied to the Digital Economy: A Proposal for a Digital Data Tax and a Global Internet Tax Agency. World Bank Group P4-5

<https://openknowledge.worldbank.org/bitstream/handle/10986/35200/9781464816543.pdf?sequence=1>

олон улсын бодлого ч үүнийг дагаад өөрчлөгдөх хэрэгтэй болсон. Улс орнуудын татварын албад дижитал компаниудын биет бус ажил гүйлгээнээс тухайн нутаг дэвсгэртээ олсон ашгаас нь татвар ногдуулах бараг боломжгүй болсон. Уламжлалт хоёр талт татварын гэрээ нь дижитал эдийн засгийн татвартай холбоотой бэрхшээлийг шийдвэрлэж чадаагүйд⁵⁰ хүрсэн.

Мөн татвар ногдуулах орлогыг зохиомлоор бууруулах зорилгоор татварын өөр өөр системийн харилцан үйлчлэлийн цоорхойг ашиглан УДК-ууд эдийн засгийн үйл ажиллагаагаа татваргүй эсвэл татвар багатай харьялал ашиглан ашгаа зувчуулж буй нь тодорхой болсон. Энэ бүхний хариуд Их20 -ийн хүсэлтээр ЭЗХАХБ нь 2013 оны 7 -р сард ТСГАШ-ийг цогц байдлаар шийдвэрлэх 15 хөтөлбөрт арга хэмжээг хэрэгжүүлэх төлөвлөгөөг зарласан (OECD, 2013)⁵¹.

Энэхүү 15 хөтөлбөр бүхий төлөвлөгөө нь гурван үндсэн баганад суурилсан болно.

- ✓ Хил дамнасан үйл ажиллагаанд нөлөөлөх дотоодын дүрэм журмын **уялдаа холбоог** сайжруулах.
- ✓ Татварыг эдийн засгийн үйл ажиллагаа, үнэ цэнийг бий болгох байршилтай уялдуулахын тулд **мөн чанарын** шаардлагыг чангатгах.
- ✓ Бизнес, засгийн газрын **ил тод байдал**, баталгааг дээшлүүлэх.

Дижитал эдийн засгийн татварын сорилтуудыг шийдвэрлэхийн тулд ТСГАШ-ийн Хөтөлбөр 1-ын тайланг 2015 оны 10 -р сард гаргасан бөгөөд дижиталчлал болон бизнесийн зарим загвар нь олон улсын татварын хувьд чухал сорилтуудыг бий болгож байгааг хүлээн зөвшөөрсөн.

2018 онд Европын холбооны дижитал үйлчилгээний татварын санал гарсан. Нэг талын дижитал үйлчилгээний татварыг хэд хэдэн оронд санал болгосон ба улс орнууд хууль батлан мөрдсөн

2020 онд ЭЗХАХБ-аас Тулгуур I, Тулгуур II төлөвлөгөөг танилцуулсан.

2021 онд АНУ-ын засаг захиргаа улс төрийн эсрэг байр сууриа буцаасан. Мөн НҮБ саналаа танилцуулсан⁵².

ЭЗХАХБ-ын санал:

- Эдийн засгийг дижитал хэлбэрт шилжүүлснээс үүдэлтэй татварын хүндрэлийн талаархи зөвшилцлийн шийдлийг боловсруулан ТСГАШ ажлын хөтөлбөрт тусгах- 28/29 2019 оны 5 -р сар
- ТСГАШ хөтөлбөр1 Дижитал эдийн засгийн татварын сорилтуудыг шийдвэрлэх
- Тулгуур 1 – Ашиг хувиарлалтын дүрэм болон холболтын өөрчлөлт
- Тулгуур 2 – Дэлхийн татварын бааз суурийн бууруулалтын эсрэг санал
- Төлөөний газар– "Эдийн засгийн чухал ач холбогдолтой" гэж юу байж болох вэ?
- Дижитал бүтээгдэхүүний үнэ шилжилтийн хэлцэл

НҮБ-ын санал:

⁵⁰ <https://taxfoundation.org/france-digital-tax-international-tax-law-trade-law-eu-law/>

⁵¹ Addressing the Tax Challenges of the Digital Economy ACTION 1: 2015 Final Report.

⁵² Prof. Piergiorgio Valente. Олон улсын татварын бодлого: Цаашдын төлөв байдал сургалт, УБ 10-р сарын 5-14 2021

- НҮБ нь дижитал үйлчилгээнд татвар ногдуулах тухай саналын төслөө гаргасан – НҮБ-ын татварын загвар конвенцид шинэ зүйл /зүйл-12б/ оруулсан
- Энэхүү шинэ заалт нь төлбөр төлөгч байрлаж буй улсдаа татвар ногдуулах боломжийг\суутган\ олгоно (онлайн зар сурталчилгааны үйлчилгээ, хэрэглэгчийн өгөгдлийг худалдах эсвэл бусад байдлаар эзэмших, онлайн хайлтын систем, онлайн зуучлалын платформ үйлчилгээ, сошиал медиа платформ, дижитал контент үйлчилгээ гэх мэт), Онлайн тоглоом, Үүлэн тооцооллын үйлчилгээ, Стандартчилсан онлайн заах үйлчилгээ).

Дижитал эдийн засгийн татваржуулалтын сорилт:

- ✓ Үнэ цэнэ бий болж буй газар – тогтоох, ялгахад хүндрэлтэй байдал
- ✓ Хуваарилалтын дүрэм – түүнийг хэрэгжүүлэх нарийн төвөгтэй байдал
- ✓ ТСГАШ ба “мөн чанар”: үнэ цэнэ бий болголт функциональ шинжилгээтэй хамааралтай эсэх

Тулгуур 1 ба 2 (ЭЗХАХБ-аас хэрэгжүүлж байгаа)

ТСГАШ төслийг хэрэгжүүлэх хөтөлбөрийг 2 тулгуур баганаар тодорхойлжээ.⁵³

- 1-р тулгуур багана - Татварын эрхээ дахин хуваарилах
- Биет оролцоогүйгээр бизнес эрхлэх асуудлыг шийдвэрлэх
 - Татвараа хаана, ямар үндэслэлээр төлөх ёстойг тогтоох
 - Ашиг орлогын аль хэсгийг үйлчлүүлэгчийн эсвэл хэрэглэгчийн байрладаг бүс нутагт татвар ногдуулах ёстойг тодорхойлох
- 2-р тулгуур багана – Татварын суурийн гажуудуулах, ашиг шилжүүлэлтийн эсрэг тэмцэх
- Шинэ технологийн тусламжтайгаар ашгийг татваргүй харьялал бүхий бус нутаг руу эсвэл бага татвартай улс руу шилжүүлэхийг зогсооход туслах
 - УДК-ийн хамгийн бага түвшний татварыг тогтоох
 - Уламжлалт болон дижитал компаниудын хоорондох тоглоомын талбарыг тэгшигтгэх

Хөтөлбөр нь цогц, зөвшилцөлд суурилсан шийдлийг боловсруулахын тулд боловсронгуй болгох шаардлагатай техникийн дизайн, хэрэгжилтийн асуудлыг судалж, ЭЗХАХБ-аас дэвшүүлсэн "Нэгдсэн хандлага"-ыг үндэс суурь болж байгаа болно.

2021 оны 12-р сар: Эдийн засгийг дижитал хэлбэрт шилжүүлснээс үүдэлтэй татварын бэрхшээлийг шийдвэрлэх хоёр тулгуурт шийдэлд 135 улс орон нэгдсэн⁵⁴(ЭЗХАХБ 2022 оны 12-р сарын байдлаар 135 улс гишүүн байгаа)⁵⁵.

⁵³ <https://www.oecd.org/tax/beps/beps-actions/action1/>

⁵⁴ Prof. Piergiorgio Valente. Олон улсын татварын бодлого: Цаашдын төлөв байдал сургалт, УБ 10-р сарын 5-14 2021,

⁵⁵<https://www.oecd.org/tax/beps/about/#:~:text=The%20OECD%2FG20%20Inclusive%20Framework,implementation%20of%20the%20BEPS%20Package>.

ДҮГНЭЛТ

1. Дижитал өөрчлөлт нь инновацийг дэмжиж, үр өгөөжийг бий болгож, үйлчилгээг сайжруулж, илүү хүртээмжтэй, тогтвортой өсөлтийг сайжруулж, сайн сайхан байдлыг дээшлүүлэхийн зэрэгцээ татварын аюулгүй байдал, татвар ногдуулалтад сорилт болж байна.
2. Дижитал эдийн засгийн татваржуулалтын маргаан, мэтгэлцээний үр дүнд дижитал орчны эдийн засгийн гүйлгээний элемент, зарчим илүү тодорхой болохын хирээр татваржуулах Тулгуур 1 ба 2 нь зохицуулах дүрэм болон хэрэгжиж эхэлж байна.
3. Монгол улс нь ТСГАШ төсөлд нэгдсэн гишүүн улс болохын хувьд дижитал эдийн засгийн гүйлгээний ангилал, бизнесийн загварын төрөл зэргийг судлан зохицуулалтыг шийдвэрлэх нь далд эдийн засгийг илрүүлэх, нийгмийн шударга байдлыг хангах замаар улс орны хөгжил, аюулгүй байдал хамгаалах нэг хэрэгсэл нь юм.
4. Дижитал бизнесийн загварт тэгш хандах хандлагыг бий болгох, олон талт стандартуудтай уялдуулах, бодлогоо тодорхойлж хэрэгжүүлэх нь дэлхийн улс орнуудад бодит ажил болсон ба энэ нь улс орнуудад дижиталчлалаас үүсэх бэрхшээлийг шийдвэрлэх, нарийн төвөгтэй байдал, нийцлийг хангах арга зүй болж байна.
5. ЭЗХАХБ-ын Тулгуур 1 ба 2 болох зохицуулах глобал дүрмийг хэрэгжүүлэлтэд улс орнууд нэгдсэн ойлголцолд хүрч баримт бичгүүд бий болсон ба 2023 оны 1-р сарын 1-ээс хэрэгжиж эхэлж байна.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

1. Алтанзаяа, Г. (2020). Татвар, Улаанбаатар хот: Монгол. x352-371
2. Алтанзаяа, Г. (2020) Дижитал эдийн засаг ба татваржуулалтын асуудал. Татвар ба Бизнес сэтгүүл. 2020/12 № 26 Улаанбаатар хот: Монгол.
3. Lyudmila V. Sanina, Oksana V. Antipina, Shuiyao Xu, (2020) Threats to tax security in the digital economy.
https://www.researchgate.net/publication/347393704_Threats_To_Tax_Security_In_The_Digital_Economy
4. Productivity, Innovation & Technology eJournal, (27 January 2020) Some Precepts of the Digital Economy. Social Science Research Network (SSRN). <https://www.researchgate.net/publication>
5. "What is digital economy? Unicorns, transformation and the internet of things".(2020) Deloitte.
6. Addressing the Tax Challenges of the Digital Economy ACTION 1: (2015) Final Report. www.oecd.org
7. Elke Asen, (2020) What European OECD Countries Are Doing about Digital Services Taxes. <https://taxfoundation.org/digital-tax-europe-2020/>
8. World Bank Group, (2020) Cristian Oliver Lucas-Mas and Raúl Félix Junquera-Varela. Tax Theory Applied to the Digital Economy: A Proposal for a Digital Data Tax and a Global Internet Tax Agency. <https://taxfoundation.org/france-digital-tax-international-tax-law-trade-law-eu-law/>
9. Prof. Piergiorgio Valente, (2021) Олон улсын татварын бодлого: Цаашдын төлөв байдал сургалт, Улаанбаатар хот: Монгол
10. <https://www.oecd.org/tax/beps/about/#:~:text=The%20OECD%2FG20%20Inclusive%20Frame,implementation%20of%20the%20BEPS%20Package>.